

АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ ОЛГОХ ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙГ 2022 ОНЫ
ХИЧЭЭЛИЙН ЖИЛД **ЭМ ЗҮЙЧ** МЭРГЭЖЛЭЭР ТӨГСӨГЧДИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТЫН **ЖИШИГ СОРИЛ – I**

Сорилын зөв хариулт

1-E, 2-C, 3-C, 4-C, 5-C, 6-C, 7-D, 8-E, 9-E, 10-A, 11-A, 12-A, 13-E, 14-E, 15-A, 16-A,
17-D, 18-A, 19-D, 20-A, 21-A, 22-D, 23-D, 24-E, 25-B, 26-C, 27-A, 28-C, 29-B, 30-D,
31-C, 32-B, 33-C, 34-A, 35-B, 36-A, 37-D, 38-E, 39-C, 40-B, 41-A, 42-C, 43-D, 44-C,
45-E, 46-A, 47-C, 48-A, 49-C, 50-D, 51-A, 52-D, 53-A, 54-E, 55-A, 56-A, 57-E, 58-A,
59-E, 60-A, 61-E, 62-A, 63-C, 64-D, 65-C, 66-C, 67-A, 68-E, 69-C, 70-E, 71-D, 72-A,
73-A, 74-E, 75-A, 76-E, 77-C, 78-A, 79-D, 80-C, 81-E, 82-E, 83-E, 84-C, 85-C, 86-E,
87-B, 88-E, 89-E, 90-C, 91-A, 92-A, 93-E, 94-A, 95-E, 96-E, 97-E, 98-E, 99-E, 100-A,
101-D, 102-A, 103-C, 104-E, 105-C, 106-E, 107-A, 108-C, 109-A, 110-A, 111-E, 112-E,
113-C, 114-A, 115-E, 116-E, 117-A, 118-A, 119-A, 120-C, 121-A, 122-E, 123-B, 124-A,
125-B, 126-C, 127-A, 128-C, 129-A, 130-C, 131-A, 132-E, 133-D, 134-A, 135-A, 136-E,
137-C, 138-A, 139-E, 140-C, 141-A, 142-A, 143-D, 144-A, 145-B, 146-C, 147-C, 148-C,
149-C, 150-B, 151-E, 152-B, 153-D, 154-A, 155-A, 156-E, 157-E, 158-A, 159-A, 160-A,
161-E, 162-A, 163-A, 164-B, 165-E, 166-E, 167-A, 168-B, 169-B, 170-E, 171-A, 172-A,
173-A, 174-D, 175-A, 176-A, 177-D, 178-A, 179-D, 180-E, 181-B, 182-A, 183-C, 184-D,
185-B, 186-E, 187-C, 188-A, 189-A, 190-C, 191-E, 192-A, 193-A, 194-A, 195-A, 196-E,
197-D, 198-A, 199-A, 200-A, 201-D, 202-A, 203-A, 204-C, 205-A, 206-B, 207-E, 208-C,
209-E, 210-E, 211-A, 212-C, 213-B, 214-C, 215-A, 216-C, 217-C, 218-C, 219-C, 220-D,
221-E, 222-C, 223-E, 224-E, 225-E, 226-E, 227-B, 228-C, 229-C, 230-B, 231-B, 232-C,
233-A, 234-C, 235-A, 236-A, 237-E, 238-C, 239-D, 240-C, 241-D, 242-C, 243-E, 244-A,
245-A, 246-D, 247-C, 248-E, 249-C, 250-E, 251-C, 252-C, 253-D, 254-C, 255-D, 256-B,
257-E, 258-D, 259-C, 260-E, 261-E, 262-D, 263-E, 264-C, 265-A, 266-E, 267-C, 268-C,
269-A, 270-C, 271-B, 272-E, 273-D, 274-D, 275-B, 276-D, 277-A, 278-C, 279-B, 280-A,
281-A, 282-A, 283-E, 284-B, 285-A, 286-A, 287-E, 288-E, 289-E, 290-A, 291-B, 292-E,
293-E, 294-E, 295-A, 296-E, 297-E, 298-C, 299-E, 300-A, 301-E, 302-B, 303-A, 304-B,
305-E, 306-C, 307-A, 308-A, 309-C, 310-C, 311-C, 312-A, 313-C, 314-C, 315-D, 316-E,
317-C, 318-D, 319-C, 320-C, 321-D, 322-B, 323-A, 324-D, 325-D, 326-B, 327-D, 328-A,
329-C, 330-C, 331-B, 332-C, 333-D, 334-D, 335-A, 336-B, 337-C, 338-C, 339-E, 340-B,
341-C, 342-D, 343-D, 344-D, 345-A, 346-C, 347-C, 348-B, 349-D, 350-C, 351-C, 352-B,
353-D, 354-C, 355-C, 356-B, 357-C, 358-D, 359-B, 360-C, 361-C, 362-D, 363-A, 364-A,
365-A, 366-A, 367-E, 368-A, 369-D, 370-A, 371-E, 372-B, 373-A, 374-A, 375-D, 376-B,
377-C, 378-B, 379-C, 380-A, 381-E, 382-C, 383-B, 384-E, 385-B, 386-B, 387-A, 388-C,
389-B, 390-D, 391-D, 392-E, 393-C, 394-C, 395-D, 396-B, 397-C, 398-B, 399-D, 400-A,
401-E, 402-D, 403-A, 404-A, 405-A, 406-A, 407-E, 408-B, 409-B, 410-A, 411-B, 412-A,
413-E, 414-C, 415-C, 416-D, 417-A, 418-C, 419-C, 420-A, 421-B, 422-E, 423-D, 424-A,
425-D, 426-B, 427-E, 428-D, 429-E, 430-C, 431-B, 432-C, 433-B, 434-E, 435-B, 436-B,
437-A, 438-E, 439-E, 440-C, 441-C, 442-B, 443-D, 444-B, 445-D, 446-D, 447-D, 448-D,
449-D, 450-A, 451-C, 452-B, 453-A, 454-B, 455-A, 456-E, 457-D, 458-E, 459-D, 460-C,
461-C, 462-B, 463-D, 464-C, 465-E, 466-C, 467-B, 468-D, 469-A, 470-C,

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
 - 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (В.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (E.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)

- Зөв, Зөв, Зөв (А.)
- Зөв, Зөв, Буруу (В.)
- Зөв, Буруу, Буруу (С.)
- Буруу, Зөв, Буруу (D.)
- Буруу, Буруу, Буруу (E.)

- /1./ Стратегийн төлөвлөлтийн чанарын шалгуурт багтах хувилбарыг сонгоно уу?
 - 1. Өндөр мэргэжлийн удирдлагыг татах чадвар
 - 2. Хэрэглэгчийн үйлчилгээний өргөжилт
 - 3. Учрах аюул саадын багасалт
 - 4. Нөөц боломжийн ашиглалт
 - 5. Зах зээлийн мэдлэгийн сайжралт
- /2./ Байгууллагын ажлын амжилтыг илэрхийлэх хүчин зүйлүүдэд аль нь орох вэ?
 - 1. Үйлчилгээний цагийн уртсалт
 - 2. Амьдрах чадварын дээшлэлт
 - 3. Гаргасан шийдвэрийн хэрэгжилт
 - 4. Хөдөлмөрийн бүтээмжийн дээшлэлт
 - 5. Материаллаг баазын нэмэгдэлт
- /3./ Шийдвэр гаргахад нөлөөлөх хүчин зүйлүүдэд багтах хувилбарыг сонгоно уу?
 - 1. Байгууллагын хүчин зүйлүүд
 - 2. Хувь хүний эрхэмлэдэг зүйл ба байгууллагын соёл
 - 3. Шийдвэр гаргах хурд
 - 4. Бүтээлч хандлага ба шинийг гаргах
 - 5. Менежерийн мэдээлэлд түшиглэх
- /4./ Удирдлагын үйл ажиллагаанд хослуулан хэрэглэх үндсэн арга нь юу бэ?
 - 1. Шаардах
 - 2. Захиргаадах
 - 3. Албадах
 - 4. Нөлөөлөх
 - 5. Удирдах
- /5./ Ямар ч байгууллагын оршин тогтнох үндэс нь юу вэ?
 - 1. Зохион байгуулалт, эрх мэдэл
 - 2. Дотоод орчин
 - 3. Материаллаг үндэс
 - 4. Гадаад орчин
 - 5. Эдийн засаг
- /6./ Удирдлагын бюрократ системийн дутагдалтай талууд:
 - 1. Хөдөлмөрийн оновчтой хувиарлалт бий болгох
 - 2. Байгууллагын доторх харилцаа холбоо сулрах
 - 3. Хөдөлмөр хамгаалалтыг орхигдуулах
 - 4. Ажиллагсадын иерарх хамаарал бий болох
 - 5. Олон шатны шаардлагагүй удирдлага бий болох
- /7./ Байгууллагын доторх олон төрлийн зөрчил даамжирч сөрөг үр дагаварт хүргэхгүйн тулд үндсэн шалтгааныг тогтоон, цаг алдалгүй зохицуулахад удирдлагын зүгээс хийх ажлын үндсэн аргууд нь юу вэ?
 - 1. Ажлын шаардлага тавих
 - 2. Хурал хийж шийдэх
 - 3. Асуудлыг эв зүйгээр зохицуулахыг хичээх
 - 4. Сахилга дэг журмыг чангатгах
 - 5. Хүмүүсийг төвлөрүүлэх, эв найртай байлгах
- /8./ Шийдвэр гаргалтын үе шатуудыг сонгоно уу?
 - 1. Асуудлыг оношлох буюу харьцуулах
 - 2. Шийдвэр гаргах хувилбаруудыг бий болгох
 - 3. Хувилбарыг үнэлэх, сонгох

4. Хамгийн оновчтой хувилбарыг сонгох
5. Шийдвэрээ хэрэгжүүлэх ба үр дүнг тооцох

/9./ Стратегийн менежментийн үйл ажилгаанд аль нь багтах вэ?

1. Дотоод орчны шинжилгээ
2. Гадаад орчны шинжилгээ
3. Стратегийн томъёололт
4. Стратегийн хэрэгжүүлэлт
5. Стратегийн хяналт

/10./ Бүлгийн шийдвэр гаргалт хэд хэдэн давуу талтай

1. Хэд хэдэн хүмүүсээс бүрдэх учир мэдээлэл хангалттай цуглуулах боломжтой.
2. Асуудал шийдвэрлэх өөр өөр аргыг бий болгодог.
3. Бүлгийн хэлцэл нь оюуны өрсөлдөөн дээр явагддаг тул зөв шийдвэр гарч, үр дүнд хүрдэг
4. Олон хүн цугладаг тул шийдвэрт хурдан хүрэх боломжтой
5. Үргэлж зөв шийдвэр гардаг

/11./ Удирдагчийн хувийн шинж чанарын үүднээс удирдлагын арга барил нь дараахь хэв маягтай байна.

1. Демократ
2. Автократ
3. Либерал
4. Уламжлалт
5. Сонгодог

/12./ Төлөвлөлтийг дараах шалтгаануудын улмаас хийдэг.

1. Тодорхой бус байдлыг багасгах
2. Зорилтыг нарийн тодруулан гаргаж ирэх
3. Үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах
4. Удирдлагыг оновчтой болгох
5. Нөхцөл байдлыг шинжлэх

/13./ Зохион байгуулалтын бүтцийг дараах хэв маягт хуваана.

1. Функциональ
2. Бүтээгдэхүүнээр хуваах
3. Газар нутгаар бүсчилэх
4. Хэрэглэгчээр хуваах
5. Матриц

/14./ Хенри Файолийн тодорхойлсон удирдлагын таван функцид дараах хувилбаруудын аль нь багтах вэ?

1. Төлөвлөх
2. Зохицуулах
3. Хянах
4. Зохион байгуулах
5. Удирдах

/15./ Шийдвэр гаргалтын үе шатуудад аль нь хамаарах вэ?

1. Асуудлыг оношлох буюу харьцуулах
2. Шийдвэр гаргах хувилбаруудыг бий болгох
3. Хувилбаруудыг үнэлэх
4. Хамгийн оновчтой хувилбарыг батлах
5. Сонгосон хувилбараа үнэлэх

/16./ Удирдлагыг эрхлэх ажил, эрх мэдэл, хамрах хүрээгээр нь түвшин тогтоон авч үзэж болно

1. Дээд
2. Дунд
3. Доод
4. Босоо
5. Хэвтээ

/17./ Байгууллагын үйл ажиллагаанд шууд нөлөөлөл үзүүлэх дотоод хүчин зүйлд дараах зүйлийг авч үзнэ :

1. Нийлүүлэгч
2. Улс төрийн бодлого
3. Өрсөлдөгч
4. Бүтэц
5. Шинжлэх ухаан, техник

/18./ Аль ч байгууллагын өмнө стратегийн үндсэн хувилбарууд байдаг. Аль нь бэ?

1. Өсөлтийг байгаа түвшинд нь барих
2. Өсөлтийг нэмэх
3. Өсөлт, бууралтыг тооцох
4. Өсөлтийг бууруулах
5. Өсөлтийг хянаж байх

/19./ Хяналтын үйл явцад багтах хувилбарыг сонгоно уу?

1. Шаардлагатай мэдээллийг цуглуулах
2. Мэдээллэлд шинжилгээ хийх
3. Үйл ажиллагаа нь төлөвлөлттэй тохирч буйг харьцуулах
4. Хэлбэлзлийг тогтоох
5. Дүгнэлт хийх

/20./ ДЭМБ-аас мөрддөг эм сонголтын шалгуурт доорхи хувилбаруудын аль нь багтах вэ?

1. Эмнэлгийн тусламжийн янз бүрийн түвшинд хэрэглэж болохоор байх
2. Элдэв гаж нөлөө багатай байх
3. Үнэ хямд байх
4. Өвчтөн уух боломжтой байх
5. Улсын бүртгэлд бүртгэгдсэн байх

/21./ Эм барих гэж юуг хэлэх вэ?

1. Эм зүйн шинжлэх ухааны дагуу эмийг найруулах
2. Эм зүйн шинжлэх ухааны дагуу эмийг савлан бэлтгэх
3. Эм зүйн шинжлэх ухааны дагуу эмийг шалгаж олгох
4. Эм зүйн шинжлэх ухааны дагуу эмийг хаяглах
5. Эм зүйн шинжлэх ухааны дагуу эмийг хадгалах

/22./ Эмийн санг зөв байрлуулахад дараах үндсэн зарчмийг тооцож үзнэ.

1. Эмийн нэр төрөл
2. Эмийн мэдээлэл сурталчилгааны асуудал
3. Дэвсгэр нутгийн хүн амын бүтэц
4. Эмийн сангийн үйлчилэх хүн амын тоо
5. Найруулж буй эмийн тоо

/23./ Ямар хилийн боомтоор эмийг оруулж ирэхийг зөвшөөрдөг вэ?

1. Алтанбулаг, Буянт-Ухаа, Замын-Үүд, Өлгий, Сүхбаатар, Цагааннуур, Эрэнцавын зэрэг ажиллагаатай боомтоор
2. Буянт-Ухаа, Замын-Үүд, Өлгий, Сүхбаатар, Цагааннуур, Алтанбулаг, Эрэннуурын зэрэг байнгын ажиллагаатай боомтоор
3. Алтанбулаг, Буянт-Ухаа, Замын-Үүд, Баян-Өлгий, Сүхбаатар, Цагааннуур, Гашуун сухайтын зэрэг байнгын ажиллагаатай боомтоор
4. Алтанбулаг, Буянт-Ухаа, Замын-Үүд, Өлгий, Сүхбаатар, Цагааннуур, Эрэнцавын зэрэг байнгын ажиллагаатай боомтоор
5. Сүхбаатар, Цагааннуур, Алтанбулаг, Буянт-Ухаа, Замын-Үүд, Өлгий, Гашуун, Эрэнцавын зэрэг байнгын ажиллагаатай боомтоор

/24./ Уламжлалт эмийн үйлдвэр үйл ажиллагаанаасаа хамааран дараах тасаг өрөөтэй байна. Үүнд:

1. Уламжлалт тан, үрэл зэхмэл эмийг боох савлах
2. Уламжлалт тан, үрэл, талх эм үйлдвэрлэх /нунтаглах-шигших- холих/
3. Ханд хэлбэрийн бэлдмэл үйлдвэрлэх /хандлах, шүүх, ханд нэрэх, өтгөрүүлэх, савлах, ус нэрэх, шил сав угаах, ариутгах /

4. Номхотгох буюу дахин боловсруулалт хийх, эмийн ургамал угаах, цэвэрлэх, холтослох үйл ажиллагаа явуулах

5. Эмт бодис, эцсийн бүтээгдэхүүн, туслах материал хадгалах, эхний материал бэлтгэх, боловсруулах

/25./ Эмийн үйлдвэрийн чанарын хяналт хариуцсан менежер нь тухайн үйлдвэрлэлийн чиглэлийн дагуу мэргэшсэн эрх бүхий эм зүйч байх ба дараах үүргийг хүлээнэ.

1. Чанарын хяналтын бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, баталгаажуулах, чанарын баталгааг хангана

2. Цувралын бүртгэлд үнэлгээ өгнө

3. Шаардлагатай бүх шинжилгээг хийх баталгааг буй болгох нөхцлөөр хангана.

4. Дээж авах зааварчилгааг боловсруулна

5. Үйлдвэрлэлийн байр ба тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ашиглана

/26./ Эмийн үйлдвэрт үйлдвэрлэж савлагдсан бүтээгдэхүүн нь дараах хаягтай байна

1. Бүтээгдэхүүний олон улсын нэр

2. Хүчинтэй нөхцөл

3. Хүчинтэй хугацаа

4. Тусгайласан анхааруулга

5. Хэрэглэх заавар тусгайлсан анхааруулга

/27./ Эмийн санд нэвтэрч буй шинжлэх ухааны хөдөлмөр зохион байгууллалтын үр дүн нь дараах үзүүлэлтүүдийн сайжралтаар илэрхийлэгдэнэ

1. Эмийг бэлтгэх хугацааны багасалт

2. Бэлэн хэлбэрийн эмийн эзлэх хувийн ихсэлт

3. Үйлчлүүлэгсэдийн эм авах хүлээлтийн хугацааны багасалт

4. Эмийн нэр төрлийн багасалт

5. Эм бэлтгэх ажилтны тооны ихсэлт

/28./ Эмнэлгийн мэргэжилтэн нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээгүл ялгаварлан тэгш, хүртээмжтэй үзүүлнэ.

1. Намын үзэл

2. Улс төрийн үзэл

3. Ажил

4. Шашин шүтлэг

5. Ажил мэргэжил

/29./ Хандив тусламжийн эмнэлгийн хэрэгсэл нь дараах шаардлагыг хангасан байна.

1. Зэвэрч хуучирч муудаагүй, эмнэлэг, эмийн сан, бусад байгууллагаас буцаагдаагүй байх

2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын чанарын сертификаттай схемтэй байх

3. Хүчинтэй байх хугацаа нь 1-1.6 жилээс доошгүй байх

4. Тээвэрлэлтэд зориулсан савлагаа нь олон улсын ачаа бараа тээвэрлэх шаардлагыг хангасан

5. Чанарын ямар нэгэн доголдол гараагүй байна.

/30./ Эмийг найруулах бүртгэх болон эмийн чанарыг шалгах аргыг заасан зайлшгүй мөрдөх стандартын түүврийг юу гэдэг вэ?

1. Эмийн стандарт

2. Эмийн үнэлэмж

3. Эмийн улсын бүртгэл

4. Фармакопей

5. Эмийн чанарын стандарт

/31./ Эм үйлдвэрлэгчдийн хувцаслалтын D – зэргийг сонгоно уу?

1. Цамц нь өндөр захтай

2. Үс, сахлыг ил гаргахгүйгээр битүү далдална

3. Ханцуйны гарын шуу талын төгсгөл хумигдсан

4. Хамгаалалтын хувцас, тэдгээрт тохирсон гутал, эсвэл гутлын гадуурх өмсгөл өмссөн

5. Пластик бээлий өмссөн

/32./ Дараах эмүүдээс жороор олгох эмийг сонгоно уу?

1. Циметидин тарилгын уусмал, шахмал

2. Циннаризин, шахмал
3. бойгар 10
4. Гарьд 13
5. Лидокайн

/33./ Үндэсний зайлшгүй шаардлагатай эмэнд хийдэг шинжилгээний аргыг сонгоно уу?

1. АВG шинжилгээ
2. АВС шинжилгээ
3. VЕН шинжилгээ
4. VEN шинжилгээ
5. VYN шинжилгээ

/34./ Эмийн үндэсний зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1. Эмийн үндэсний бодлогын асуудлаар санал, зөвлөмж боловсруулж, төрийн захиргааны холбогдох төв байгууллагад оруулах
2. Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтад өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах
3. Эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах
4. Мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн жагсаалтыг батлах
5. Эмийн улсын стандарт, фармакопег батлах

/35./ Иргэний хувийн хэрэглээнд зориулан Монгол улсын хилээр оруулахыг хориглох эмийн нэр төрөл

1. Сүрьеэ эмчлэх эм
2. Антибиотик /тариа/
3. Вакцин
4. Цус сэлбэх шингэн
5. Өнчин эм

/36./ Эм ханган нийлүүлэх байгууллагын мэргэжлийн ажилтны бүрэлдэхүүн дараах доод хязгаарыг хангасан байна

1. Эм худалдааны менежер – Эм зүйч
2. Эмийн чанарын менежер – Эм зүйч
3. Бэлтгэгч, олгогч - Эм зүйч эсвэл эм найруулагч
4. Захиалга хүлээн авагч - Эм зүйч
5. Олгогч-Эм найруулагч

/37./ Ямар эмийг импортлох вэ?

1. Эмийн улсын бүртгэлд бүртгэгдэх гэж байгаа эмийг
2. Яаралтай тусламжинд шаардлагатай эмийг
3. Улсын бүртгэлд бүртгэгдсэн эмийг
4. Ховор тохиолддог өвчнийг эмчлэхэд харьцангуй бага хэмжээгээр хэрэглэгддэг эм

/өнчин эм/

5. Төлбөргүй тусламжийн эмийг

/38./ Эмийн үйлдвэрийн зарим онцгой аюултай материалын дээж авах үйл ажиллагаанд тусгай сэрэмжлүүлэг шаардана. Дээж авсан сав бүр дараах хаягтай байна.

1. Дээж болон савлагдсан материалын нэр
2. Цувралын дугаар
3. Дээж авсан савны дугаар
4. Дээж авсан хүний гарын үсэг
5. Дээж авсан он сар өдөр

/39./ Эмийн хэрэгцээг тодорхойлохдоо нийт эмүүдийг хэд хэдэн бүлэгт хувааж хэрэгцээг тооцож болно. Аль нь зөв вэ?

1. Тасалдалтай байгаа эмүүдийн
2. Өргөн хэрэгцээний эмүүдийн
3. Хэрэглээнд шинээр нэвтэрч байгаа эмүүдийн
4. Мансууруулах, өвөрмэц үйлдэлтэй, нормчлогдсон эмүүдийн
5. Ховор өвчинд хэрэглэгддэг эмүүдийн

/40./ Үнэ төлбөргүй эмчилгээг аль өвчний тохиолдолд хийх вэ?

1. Сүрьеэ

2. Хорт хавдрын III, IV үе шат (хөнгөвчлөх эмчилгээ)
 3. Сэтгэцийн эмгэг
 4. Оюуны хомсдол (F7.0 – F7.9)
 5. Нөхөн сэргээх эмчилгээ
- /41./ Эмийн мэдээлэл сурталчилгаа ямар байх ёстой вэ?
1. Үнэн
 2. Зөв
 3. Бодит
 4. Үйлдэл, үр дүнг магтсан
 5. Үнэ боломжийн болохыг сурталчилсан
- /42./ Өвчтөнд олгох эм, биобэлдмэл дараах мэдээллийг агуулсан хаяглалттай байна
1. Эм, биобэлдмэлийн хүчинтэй байх хугацаа
 2. Эм, биобэлдмэлийн нэр
 3. Эм, биобэлдмэлийн орос, монгол нэр
 4. Хэрэглэх арга
 5. Үйлдвэрлэсэн улсын код
- /43./ Мансууруулах, сэтгэц нөлөөт болон хүчтэй үйлдэлтэй эмийг гэрээр олгох тохиолдолд хэний гарын үсэгтэй жороор олгох вэ?
1. Эмчлэгч
 2. Эмийн сангийн эрхлэгч
 3. Эмнэлгийн дарга
 4. Ерөнхий эмч
 5. Өрхийн эмч
- /44./ Эм барааны нөөцийн тасгийн эрхлэгч нь дараах бүртгэлүүдийг хөтөлнө
1. Найруулсан эмийн бүртгэл
 2. Эм барааны нэр төрлийн карт
 3. Жорын бүртгэл
 4. Хугацаат эмийн бүртгэл
 5. Эм барааны бүртгэл
- /45./ Улсын бүртгэлд бүртгүүлэх эм нь дор дурдсан нөхцлийг хангасан байна. Үүнд:
1. Найрлага нь нарийвчлан тогтоогдсон
 2. Үйлдэл нь бүртгэгдсэн ижил төстэй эмийнхээс давуу, гаж нөлөө харилцан үйлчлэл багатай
 3. Монгол улсын эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэж байгаагүй үйлчлэгч бодис бүхий эм нь гадаадын 3-аас доошгүй улсад бүртгэгдсэн
 4. Гарал үүслийн улсын эмийн бүртгэлд бүртгэгдээд 3-аас доошгүй жил болсон
 5. Эмийн хэрэглэх заавар, шошго нь Монгол, Англи эсвэл Орос хэл дээр байна
- /46./ Эм биобэлдмэлийн жорын ач холбогдол нь юу вэ?
1. Санхүүгийн
 2. Хуулийн
 3. Анагаах ухааны
 4. Эмийн чанарын
 5. Эмийн технологийн
- /47./ Ургамлын гаралтай эмийн түүхий эдийг дараахь нөхцөлд хадгална.
1. Эфирийн тос агуулсан эмийн ургамлын түүхий эдийг сайн саванд тусад нь хадгална
 2. Урьдчилан хатаасан эмийн ургамлын түүхий эдийг хуурай, агааржуулалт сайтай байранд цаасан болон тохирох саванд хадгална.
 3. Хатаасан эмийн ургамлын түүхий эдийг битүү шилэнд хадгална.
 4. Мансууруулах болон сэтгэц нөлөөт үйлдэлтэй ургамлын түүхий эдийг тусгаарласан байранд эсвэл тусгай цоожтой шүүгээнд хадгална.
 5. Мансууруулах үйлдэлтэй ургамлын түүхий эдийг эрхлэгчийн зөвшөөрлөөр зарцуулна
- /48./ Эм үйлдвэрлэлийн эхний материалд тавигдах шаардлагуудыг сонгоно уу?
1. Хангагч байгууллагаас нийлүүлсэн эхний материалын савлалтын бүрэн бүтэн байдал, лац тэмдэг, захиалга, нийлүүлэлтийн мэдэгдэл ба хангагчийн хаяг зэрэг нь хоорондоо тохирч буйг шалган огноо бичмэл хаяг нааж, баримтжуулна.

2. Үйлдвэрлэлд эхний материал нь GMP – н шаардлага хангасан үйлдвэрлэгчийн чанарын сертификаттай, эрх бүхий байгууллагын итгэмжлэгдсэн лабораториор баталгаажсан байна.

3. Хадгалах онцгой температур, чийг болон тусгай нөхцөл шаардагддаг материалыг горимын дагуу хадгалан, шалгаж тэмдэглэл хөтлөнө.

4. Мансууруулах, сэтгэц нөлөөт эм, цацраг идэвхит бодис, тэсэрч дэлбэрэх материал болон бусад хор хөнөөл ихтэй зүйлс хүлээн авах, хадгалах, тэдгээртэй ажиллахдаа бүртгэл хөтөлнө.

5. Эхний материалыг зөвхөн яанарын менежерийн хяналтан дор агуулахаас гаргаж, жинлэлтийг хянаж бүртгэнэ.

/49./ Хандив, тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийг хэрхэн зарцуулах вэ?

1. Хандив, тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийг зориулалтаар хэрэглэхийг эрхэмлэнэ.

2. Хандив, тусламж хүлээн авагч байгууллага нь эм, эмнэлгийн хэрэгслийн эргэлтийн хөрөнгөдөө бүртгэн авч ашиглалтад хяналт тавьж байна.

3. Хандив, тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийг зарж борлуулахгүй.

4. Хандив, тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийг зөвхөн эмнэлгийн өвчтөний хэрэгцээнд зарцуулна

5. Хандив, тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийг мэргэжлийн хяналтын байгууллага хянаж байна.

/50./ Анагаах ухааны орчин үеийн ёс зүйн онолын үндсэн үзэл баримтлалд аль нь хамаарах вэ?

1. Зах зээлийн үзэл баримтлал

2. Эртний үзэл баримтлал

3. Өнөө үеийн үзэл баримтлал

4. Орчин үзэл баримтлал

5. Консивинциаль онол

/51./ Эмийн санд бэлтгэсэн эмийн бэлдмэл нь эмийн сангийн дараах дотоод хяналт шалгалтанд хамрагдана.

1. Бичгийн

2. Мэдрэхүйн эрхтэний

3. Асуух

4. Зөвхөн амтлах

5. Олгох үеийн хяналт

/52./ Эм найруулгын өрөөны тавилга төхөөрөмж, материал хэрэгслийн байршил, эм найруулагчийн хийх үйлдэл нь хэдээс хэдэн градусаас дээшгүй тонгойхоор байх ёстой вэ?

1. 15

2. 30

3. 25

4. 20

5. 35

/53./ Ариун эмийн үйлдвэрлэлийн байрны агаарын цэвэршилтийн "А" ангиллыг сонгоно уу?

1. 0.5 – 5µm/микромметр/-3500

2. 5µm/микромметр-1;

3. 1м3 агаарт байж болох нянгийн зөвшөөрөгдөх хамгийн их тоо -1-ээс бага

4. 0.5 – 5µm/микромметр/-3500; 5µm/микромметр-1; 1м3 агаарт байж болох нянгийн зөвшөөрөгдөх хамгийн их тоо -1-ээс бага;

5. 0.5 – 5µm/микромметр/-3500; 5µm/микромметр-1;

/54./ Эрүүл мэндийн санхүүжилт нь ямар эх үүсвэрээс бүрдэх вэ?

1. Иргэний эрүүл мэндийг хамгаалах тусгай сан

2. Улс, орон нутгийн төсөв

3. Байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, иргэний хандив

4. Эрүүл мэндийн даатгал

5. Гадаадын зээл, тусламж

/55./ Эмийн үйлдвэрлэл эрхлэхэд хориглох зүйлийн талаар эмийн тухай хуульд юу гэж заасан бэ?

1. Эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эм үйлдвэрлэх
2. Хүний зориулалттай эмийг мал, амьтны зориулалттай эмтэй нэг дамжлага дээр үйлдвэрлэх
3. Хүний зориулалттай эмийг мал, амьтны зориулалттай эмтэй нэг шугам дээр үйлдвэрлэх

4. Эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм үйлдвэрлэх
 5. Дууриамал болон хуурамч эмийг үйлдвэрлэхгүй байх
- /56./ Эм хангамжийн байгууллага нь дараахь нийтлэг үүргийг хүлээнэ

1. Эм ханган нийлүүлэх байгууллага нь эм, эмнэлгийн хэрэгслээр эрүүл мэндийн байгууллагыг ханган нийлүүлнэ
2. Эмийн сан, түүний салбар нь эм, эмнэлгийн хэрэгслийг эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлэгд жижиглэн худалдаална
3. Эм хангамжийн байгууллага нь шаардлагыг хангасан байна
4. Эм хангамжийн байгууллага нь ашиг орлогоо нэмэгдүүлэхийн зорилгоор эмнэлгийн мэргэжилтнийг эм, эмнэлгийн хэрэгсэл борлуулах, үр дүнгээр нь урамшуулах буюу түүнийг адилтгах үйл ажиллагаанд оролцуулахыг хориглоно.
5. Хуурамч эм импортлох, үйлдвэрлэх, худалдана.

/57./ Эмнэлгийн эмийн эмчилгээг зохицуулах хороо дараах үүрэг хүлээнэ:

1. Эмнэлгийн эмч, мэргэжилтэн, үйлчлүүлэгчдэд шинэ эм хэрэглэх, эмийн талаар үнэн зөв, бодит мэдээллээр хангах, тэдний эмийн хэрэглээний талаархи мэдлэгийг дээшлүүлэх, сургалт зохион байгуулах;
2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардагдах эмийн жагсаалтыг гаргах, сонголтын талаар зөвлөх;
3. Байгууллагын онцлогт тохирсон эмийн лавлах тогтмол гаргах, эмчилгээний удирдамж (стандарт) боловсруулахад эмч, мэргэжилтэнд туслах;
4. Эмийн гаж нөлөөг бүртгэх, тандах, үнэлгээ өгөх, мэдээлэх, сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах;
5. Жорын маягт, жор бичилтийн стандартын мөрдөлт, жорын маягтын хангалт, хүртээмж, жор бичилтийг оновчтой болгоход чиглэсэн арга хэмжээ зохион байгуулан, хяналт тавьж ажиллах;

/58./ Хөдөлмөр зохион байгуулалт, хөдөлмөрийн үйл ажиллагааг дараах аргуудаар судална.

1. Ажлын цагийн зарцуулалтаар судлах
2. Ажиллагсадын өвчлөлийг эмнэлгийн хуудас ба эрүүл мэндийн үзлэгээр судлах
3. Тохиолдолыг ажиглан бүртгэх
4. Шинжилгээний аргууд
5. Ажлын цагийн бүртгэлээр судлах

/59./ Дараах эмийн бэлдмэлийг бүртгэлд бүртгэнэ. Үүнд:

1. Монгол улсын эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэж байгаагүй үйлчлэгч бодис бүхий эм
2. Эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эм
3. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн уламжлалт эм тан
4. Хоногийн дээд тун нь эмчилгээний тун бүхий аминдэм, эрдсийн бэлдмэл
5. Үндсэн үйлчлэгч бодис болон туслах бодис өөрчлөгдсөн бүртгэлтэй эм

/60./ Эмийн зохистой хэрэглээнд оролцдог 3-н үндсэн элементийг сонгоно уу?

1. Эмч
2. Өвчтөн
3. Эм зүйч
4. Сувилагч
5. Хүн ам

/61./ Эм ханган нийлүүлэх байгууллага нь дараах нэгжтэй байна.

1. Удирдлага
2. Захиалга хүлээн авах, олгох
3. Бэлтгэн нийлүүлэх
4. Агуулах

5. Чанарын хяналт

/62./ Эмийн чанарын менежер дараах үйл ажиллагааг эрхэлнэ.

1. Эмийн чанарын баталгаажуулалт, хадгалалт, чанарын хяналт тавьж хүлээн авсан бүх эмийн хүчинтэй хугацаа болон чанарын баталгаажилтын бүртгэл хөтөлнө

2. Эм ханган нийлүүлэх байгууллагын үйл ажиллагааны дотоод дүрэмд заагдсны дагуу бүх шат дамжлагад хяналт тавина

3. Жин, хэмжих бусад хэрэгсэл нь баталгаажуулагдсан, графикайн дагуу тохируулга хийгдсэн эсэхэд хяналт тавина

4. Тээвэрлэлтийн явцад хагарсан, асгарч холилдсон, хадгалалтын явцад чанар нь муудсан эмийг актална

5. Эмийн үйлдвэрлэлийн сертификатыг шалгана

/63./ Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлтийн технологийн шаардлагыг хангаагүй нөхцөлд үйл ажиллагаа явуулбал албан тушаалтан, байгууллагад ямар торгууль ногдуулах вэ?

1. 15000-25000, 50000-100000₮

2. 10000-20000₮

3. 150000-250000₮

4. 100000-200000₮

5. 10000-20000, 100000-300000₮

/64./ Эмийн сан нь Дигоксин тариаг хэрэглэгчдэд хэрхэн олгох вэ?

1. Эмчийн жороор

2. Жоргүйгээр

3. Эмийн санчийн шийдвэрээр

4. Стационарт

5. Өрхийн эмчийн шийдвэрээр

/65./ Аль ч зэрэглэлийн эмийн санд хориглох зүйлүүд

1. Соёлын болоод гоо сайхны бараа худалдаалах

2. Эмийн хэлбэрүүдийг үйлдвэрлэх

3. Усан уусмал найруулан бэлтгэх

4. Галены бэлдмэл үйлдвэрлэх

5. Бөөн эмийг жижиглэн савлаж худалдаалах

/66./ Монгол улсын эмнэлгийн практикт хэрэглэх мансууруулах, сэтгэц нөлөөт болон хүчтэй үйлдэлтэй эмийн жагсаалтын мансууруулах эмийн бүлэгт багтах эмүүдийг сонгоно уу?

1. Галоперидол

2. Трамадол

3. Нитрозепам

4. Петидин

5. Фентазин

/67./ Нийлмэл эмийн жорыг бичих дараалалыг сонгоно уу ?

1. basis adjuvans

2. adjuvans

3. corrigens

4. basis

5. basis corrigens

/68./ Төлбөрийг нь төрөөс дааж амбулатори, поликлиникээр үнэ төлбөргүй олгох эмийн жагсаалтад багтах эмүүдийг сонгоно уу?

1. Хлорпромазин (шахмал, 100 мг, гидрохлорид)

2. Галоперидол (шахмал, 2 мг, 5 мг)

3. Флуфеназин (шахмал, 10, 20 мг, деканоат)

4. Диазепам (шахмал, 2 мг, 5 мг)

5. Амитриптилин (шахмал, 10 мг)

/69./ Хүлээн авагчаас буцаасан эм нь дор дурдсан шаардлагыг хангасан нөхцөлд эм хадгалах үндсэн хэсэгт шилжүүлж болно

1. Буцаагдсан бараа зохих журмын дагуу хадгалагдаж байсныг нотлох бичигтэй

2. Өөрийн анхны савалгаанд задрал гэмтэлгүй байгаа

3. Буцаагдсан эмийн чанар нь шаардлагад тохирч буй нь холбогдох бичиг баримтаар батлагдаж байгаа

4. Хүчинтэй хугацааны үлдсэн хугацаа нь 1/3-ээс хэтрээгүй

5. Буцаагдсан эмийн чанар нь фармакопейн шаардлагад тохирч буй нь холбогдох бичиг баримтаар батлагдаж байгаа

/70./ Эмийн йлдвэрийн үйл ажиллагааны баримтжуулалт нь дараах бүртгэлээс бүрдэнэ. Үүнд:

1. Эхний материалыг хүлээн авсан бүртгэл

2. Дамжала дундын хяналтын бүртгэл

3. Үйлдвэрлэлийн цувралын бүртгэл

4. Эцсийн бүтээгдэхүүнийг худалдаанд гаргасан бүртгэл

5. Зах зээлээс буцан татсан бүтээгдэхүүний бүртгэл

/71./ Консивинциаль онолын үзэл баримтлал нь юу вэ?

1. Үйлдэл, үйл ажиллагааны зөв буруу нь түүнийг төрүүлсэн сэдлээс (санаатай ба санамсаргүй үйлдэл) хамаарна

2. Ухамсарласнаас үйлдлийг хийж байна уу, эсвэл айснаас хийж байна уу гэдгээс хамаарна.

3. Үйлдэл, үйл ажиллагааны зөв буруу нь түүнийг төрүүлсэн сэдлээс (санаатай ба санамсаргүй үйлдэл) хамаарахгүй байх.

4. Үйлдэл, үйл ажиллагааны үр дүн нь учруулах хохирлоос их байна гэвэл зөв, бага байвал буруу байна гэж үздэг онолын үзэл баримтлал.

5. Үйлдэл нь учруулах хохирлоос их байна гэвэл зөв, бага байвал буруу байна гэж үздэг онолын үзэл баримтлал юм.

/72./ Ариун эм үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэдэн зэрэглэлд хуваах вэ?

1. Бэлдмэлийг эцсийн саванд савлаж битүүмжлэн ариутгадаг

2. Бэлдмэлийг шүүх аргаар ариутгадаг

3. Бэлдмэлийг шүүх аргаар болон дулааны аргаар ариутгаж болдоггүй, зөвхөн үжилгүй нөхцөлд ариутгасан эхний материалаар бэлтгэдэг.

4. Бэлдмэлийг шүүдэг

5. Бэлдмэлийг үөвхөн дулааны аргаар хийдэг.

/73./ “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн журам”-д эмнэлгийн мэргэжилтэн нь ямар эм худалдахыг хатуу хориглоно гэж заасан бэ?

1. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй

2. Үр дүнгийн талаар тодорхойгүй

3. Стандартын зохих шаардлага хангаагүй

4. Үйлдвэр нь тодорхой биш

5. Үнэ өндөр

/74./ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг дор дурьдсан зорилгоор дараахь байгууллага ашиглаж болно.

1. Эмчилгээ, шинжилгээ, судалгааны зорилгоор эмнэлэг

2. Лабораторийн шинжилгээ хийх зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих үүрэгтэй байгууллага

3. Харьцуулалт хийх, зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйл ажиллагааг илчлэх зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллага;

4. Эмчилгээ, шинжилгээ, судалгааны зорилгоор эрдэм шинжилгээний байгууллага

5. Сургалт явуулах зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих үүрэгтэй байгууллага

/75./ Хаягдлыг ялгасны дараа савлах уут, хайрцгийг өнгөөр ялгаж төрөлжүүлнэ. Үүнд:

1. Ердийн хаягдалыг хар өнгийн уут, саванд хийнэ.

2. Эмнэлэг- үйлчилгээний хог хаягдлыг шар өнгийн уут, саванд хийж олон улсын биологийн болон халдвартай хог хаягдлыг таних тэмдгийг тавина.

3. Хими цацраг идэвхитэй, эсэд хортой нөлөө үзүүлдэг хаягдлыг хүрэн өнгийн уут, саванд хийж, тус тусын таних тэмдэг тавина.

4. Халдварын зэрэглэл өндөртэй хаягдлыг цагаан өнгийн уут, саванд хийж халдвартай гэж бичнэ.

5. Щприц зэргийг улаан уутанд хийнэ
- /76./ Эмнэлгийн мэргэжилтэн дор дурьдсан үүрэг хүлээнэ.
1. Эмнэлгийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг биелүүлнэ
 2. Хүнлэг энэрэнгүй үзлийг эрхэмлэнэ
 3. Мэргэжлээ хүний эрүүл мэндийн эсрэг ашиглахгүй
 4. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, сургалт, сурталчилгаа явуулах, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх
 5. Иргэний эрүүл мэндийн болон байгууллагын нууцыг хадгалах
- /77./ Эмийн түгээлтийг онолын хувьд хэдэн түвшинд хуваадаг вэ?
1. Улс хоорондын
 2. Бүсийн
 3. Аймгуудын
 4. Олон улсын
 5. Сумын
- /78./ Эм барааны гүйлгээний зардлыг өсгөх үзүүлэлтэнд ямар ямар үзүүлэлтийг авах вэ?
1. Үйлчлүүлэгчдийг үйлчлэх зардлын өсөлт
 2. Эмээр үйлчлэх ажлын соёлжилтыг дээшлүүлэх
 3. Ажилчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх
 4. Эм бараа борлуулалтын өсөлт
 5. Бэлэн хэлбэрийн эмийн эзлэх хувийн жингийн өсөлт
- /79./ Эмийн сангийн худалдааны орлого, жижиглэнгийн ба бөөний эм борлуулалт нөлөөлөх объектив хүчин зүйлүүдийг сонгоно уу?
1. Эмийн дундаж үнэ
 2. Гүйлгээний зардлын төвшин
 3. Орлогын төвшин
 4. Эмийн үнийн өөрчлөлт
 5. Ашиг
- /80./ Эмийн сангийн эдийн засгийн дараах үзүүлэлтүүдийг тодорхойлоход жорын үзүүлэлтийг ашиглана. Зөв хувилбаруудыг сонгоно уу?
1. Эм бараа татан авалт
 2. Эмийн сангийн орон тоо
 3. Эмийн сангийн ашиг
 4. Туслах материалын зардал
 5. Эмийн сангийн борлуулалт
- /81./ Эм бараа борлуулалтад холбогдох мөнгөн илэрхийллийн тоон үзүүлэлтүүдэд юу юу хамаарагдах вэ?
1. Эм барааны эхний үлдэгдэл
 2. Нөөц
 3. Татан авалт
 4. Борлуулалтын дүн
 5. Барааны эцсийн үлдэгдэл
- /82./ Эмийн сангийн жижиглэнгийн бараа борлуулалтад нөлөөлөх дараах хүчин зүйлүүдийг төлөвлөлтөд анхаарах нь зүйтэй. Зөв хувилбаруудыг сонгоно уу?
1. Хүн амын тоо ба нягтрал, хүн амын насны бүлэг
 2. Улирлын хэлбэлзэл
 3. Барааны хангамж, нийлүүлэлт, нэр төрөл
 4. Мэдээлэл сурталчилгаа, эмч нарын эмийн мэдээллийн хангамж
 5. Эмийн сангийн байрлал
- /83./ Эм бараа борлуулалтад холбогдох мөнгөн илэрхийллийн чанарын үзүүлэлтүүдэд юу орох вэ? Зөв хувилбарыг сонгоно уу?
1. Эм бараа борлуулалтын группын бүтэц
 2. Хүн ам
 3. Эмнэлгийн байгууллагын эм барааны эрэлтийн хангалтын байдал
 4. Өвчлөл
 5. Шинэ эмийн нэвтрэлт

- /84./ Бэлтгэн нийлүүлэгчээс эм бараа татан авахад ямар баримтыг үндэслэл болгох вэ?
1. Эм борлуулалтын мэдээ
 2. Гэрээ
 3. Тайлан
 4. Зарлагын падаан
 5. Орлогын ордер
- /85./ Эмийн сангийн бүртгэл тооцооны дараах төрлүүд байна
1. Судалгааны бүртгэл
 2. Статистик, ня-бо бүртгэл
 3. Тайлангийн систем
 4. Өдөр тутмын анхан шатны бүртгэл
 5. Эдийн засгийн бүртгэл
- /86./ Ерөнхий журналыг дараах зориулалтаар ашиглана. Зөв хувилбаруудыг сонгоно уу?
1. Жижиг аж ахуй нэгжүүд үйл ажиллагааны бүх ажил гүйлгээг дансанд бүртгэх үндсэн журналын хэлбэрээр бүртгэх
 2. Дэлгэрэнгүй бүртгэлээс ажил гүйлгээг ерөнхий дансанд бүртгэх
 3. Ямар ч журналд бүртгэх боломжгүй, эсвэл бүртгэгдээгүй орхигдсон ажил гүйлгээг бүртгэлд тусгах
 4. Бүртгэгдсэн ажил гүйлгээг залруулах, тохируулах
 5. Ямар нэг хаалтын бичилт хийх
- /87./ Эмийн сан нь ажилчдын хөдөлмөр цалин хөлсийг тооцоход ажилчидаа үндсэн 2-н ангилалд хуваадаг ба захиргаа аж ахуйн хэсэгт ямар ажилчид орох вэ?
1. Эм шинжлэгч буюу эмийн чанар хариуцсан мэргэжилтэн
 2. Дефектар буюу эмийн хангамж, борлуулалт эрхэлсэн менежер, нөөцийн тасгийн эрхлэгч
 3. Карт хөтлөгч буюу дефектарын туслах, захиалга бэлтгэгч
 4. Ерөнхий болон тооцооны нягтлан бодогчид
 5. Жор баригч
- /88./ Тооцооны ажилтнууд доорхи үүрэгт ажлыг гүйцэтгэнэ. Зөв хувилбаруудыг сонгоно уу?
1. Тооцооны баримтуудад худалдаа үйлдвэрлэл, санхүү аж ахуйн үйл ажиллагааг үнэн зөв тусгана.
 2. Техник төхөөрөмж, багаж хэрэглэл, бараа материалын үнэт зүйлс, мөнгөн хөрөнгийн бүрэн бүтэн байдалд бүртгэлээр хяналт тавина.
 3. Хөрөнгийг үрэн таран хийх, үргүй зардал гаргах, дутааж шамшигдуулах явдлаас сэргийлж, хяналт тавьж ажиллана.
 4. Ажиллагсадын орон тооны мөрдөлт, санхүү мөнгөний сахилга батад хяналт тавьж төлбөр тооцоог цаг тухайд нь хийж ажиллана.
 5. Хөрөнгийн янз бүрийн зарлага нь хууль эрх зүйн актуудын заалтад нийцэж, зайлшгүй зүйлд зөв зарцуулагдаж байгаа эсэх, батлагдсан, төлөвлөсөн хэмжээнд багтаж байгаа эсэхийг хянана.
- /89./ Эм бараа борлуулалтыг төлөвлөхийн тулд дараах ажлуудыг хийх шаардлага гарна. Зөв хувилбаруудыг сонгоно уу?
1. Эмийн сангийн эм бараа борлуулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл, түүний бүтцийг олон жилээр судлах
 2. Эм бараа борлуулалтын өсөлтийн темп, түүний хандлагыг тодорхойлох
 3. Эм бараа борлуулалтын бүтцийг хүн амд, эмнэлгийн байгууллагад, бусад газарт худалдсан эм барааны бүлэг, нэр төрлийг судлах
 4. Эм бараа борлуулалтанд нөлөөлж буй эм барааны нөөц, нэр төрөл бүрдүүлэлт, захиалалт, нийлүүлэлт, татан авалт, хувиарлалт, тээвэрлэлт, эмийн эрэлт, хэрэглээ, ажлын зохион байгуулалт зэрэг хүчин зүйлүүдийг судлах
 5. Борлуулалтыг нэмэгдүүлэх дотоод нөөц бололцоо, үйлчилгээний хүрээ, салбар цэгийг нэмэгдүүлэх боломжийг судлах.
- /90./ Эмийн сангийн үйл ажиллагааны зардлыг бууруулахад ямар хүчин зүйлсүүд нөлөөлөл үзүүлдэг вэ?
1. Эм бараа борлуулалтын бууралт

2. Аж ахуйн тооцооны боловсронгуй бололт, хөрөнгийн хяналтын тогтолцооны сайжралт
 3. Бэлэн хэлбэрийн эмийн эзлэх хувийн багасалт
 4. Ажиллагсадыг зөв байршуулах
 5. Эм барааны өөрийн өртгийн өсөлт
- /91./ Эмийн сангийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтэнд аль аль үзүүлэлтүүд хамрагдах вэ?
1. Цэвэр ашиг
 2. Худалдааны орлого
 3. Эм бараа борлуулалт
 4. Жор хүлээн авалт
 5. Үйлчилсэн хүний тоо
- /92./ Дараах тохиолдолд ээлжит бус ба гэнэтийн, хяналтын тооллого хийгдэнэ.
1. Хууль хяналтын байгууллага ба дээд байгууллагаас шалгах үед
 2. Санхүүгийн байгууллагаас баримтын шалгалт хийх үед
 3. Эм барааны үнэ өөрчлөгдөх үед
 4. Үнийн дүнгээр (мөнгөн дүнгээр) тооцоо бодуулдаг эд хариуцагчид (жор баригч) - ийн эм бараа материал, сав боодол, туслах материалын тооллогын үед
 5. Нэр төрлөөр тооцоогоо бодуулдаг эмийн агуулах буюу дефектарын хариуцсан эм барааны тооллогын үед
- /93./ Эмийн сангийн ажилчдын орон тоог төлөвлөхдөө мэргэжлийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт болох жор хүлээн авалт ба эдийн засгийн үндсэн үзүүлэлт болох эм бараа борлуулалт болон нөлөөлөл үзүүлэх дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзэх шаардлагатай байдаг Зөв хувилбарыг сонгоно уу?
1. Эмийн сангийн хэлбэр
 2. Эмийн сангийн үйлчилгээний хүрээ
 3. Эмийн сангийн бүтэц, үйлчилгээний нэр төрөл
 4. Эмийн сангийн үйлчилгээний цаг
 5. Эмийн сангийн салбарын тоо
- /94./ Эмийн сангийн үндсэн үзүүлэлтүүдийг статистик аргаар төлөвлөнө гэдэгт дараах аргуудыг оруулна
1. Дундаж хэмжигдэхүүнээр
 2. Өсөлтийн темпээр
 3. Динамик эгнээний үзүүлэлтээр
 4. Тогтоосон нормативаар
 5. Үзүүлэлтүүдээр уялдуулж баланслуулах
- /95./ Нягтлан бодох бүртгэлийн аргууд нь тайлан тэнцэл гаргахад баримталда++9-г үндсэн дүрэм буюу нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмуудад үндэслэгдэнэ. Нягтлан бодох бүртгэлийн дараах аргууд байна. Зөв хувилбарыг сонгоно уу?
1. Баланс-тайлан
 2. Данс-давхар бичилт
 3. Баримт-баримтжуулалт
 4. Үнэ-үнэлгээ (калькуляци зохиох)
 5. Тооллого-тооцоо
- /96./ Эмийн сангийн аж ахуйн үйл ажиллагааны өдөр дутмын байдлыг тооцооны данснуудад дараах байдлаар бичилт хийнэ. Зөв хувилбаруудыг сонгоно уу?
1. Аж ахуйн үйлдэл актив, пассив хэсэгт 2 дахин бичигдэнэ
 2. Активын дебетэд бичигдсэн тооцоо нь пассивын кредитэд бичигдэнэ
 3. Пассивийн дебет (-), кредит (+) байна
 4. Пассивт дебет (-) кредит (+) байна
 5. Активын дебет (+), кредит (-) байна
- /97./ Эм хангамжийн байгууллагуудын эм барааны эргэлт ямар ямар хүчин зүйлүүдээс шалтгаалах вэ?
1. Эм бараа татан авалтыг шуурхай болгож, хэрэглэгчдэд аль болох түргэн хугацаанд хувиарлаж хүргэх
 2. Захиалсан тоо хэмжээний нэр төрлийн эмийн нийлүүлэлт

3. 3. Эмийн зөв хадгалалт, агуулахын менежмент, эмийн чанарын доголдол, хорогдол гарахаас сэргийлэх арга хэмжээ

4. 4. Эмийг зориулалтын дагуу түргэн шуурхай борлуулж, хэрэглэгчдэд хүргэх үйл ажиллагаа, эмийн нэр төрөл бүрдүүлэлт

5. 5. Эмийн мэдээлэл сурталчилгааны ажил

/98./ Эмийн сангийн үйл ажиллагааны бүртгэл тооцооны гол зорилт нь юу вэ?

1. Эмийн сангийн үндсэн үзүүлэлтүүд, төлөвлөгөөт зорилтуудын биелэлтэнд мэргэжлийн болоод эдийн засгийн хяналт тавих

2. Өмч хөрөнгийн хамгаалалтыг хянах

3. Үргүй зардлыг багасгах

4. Үйл ажиллагаа, хөрөнгө мөнгөний ойрын болон хэтийн төлөвлөлтийг зөв хийх

5. Ашиг орлоготой ажиллах боломжийн мэдээллийг гаргаж, удирдлагын зүгээс анхаарч хийх асуудлын цаашдын чиглэлийг өгөх

/99./ Санхүү тооцооны бүртгэл баримтууд нь дараах агуулгыг дотроо багтааж, бүрдэл болсон байна. Зөв хувилбаруудыг сонгоно уу?

1. Бүртгэл баримтын нэр, дугаар, хөтөлсөн огноо

2. Уг баримтыг үйлдэж буй байгууллагын нэр, хаяг

3. Уг үйлдэлд оролцож буй харилцагч байгууллагын нэр, хаяг

4. Аж ахуйн үйлдэлийн агуулга, бүртгэлийг бичих болсон шалтгаан

5. Оролцогч талуудын болон хянаж шалгасан этгээдийн гарын үсэг

/100./ Эмийн сангийн худалдааны орлого, түүний түвшинд ямар үзүүлэлтүүд нөлөөлөх вэ?

1. Эм барааны жижиглэнгийн болон бөөний үнийн өөрчлөлт

2. Эм бараа борлуулалтын хэмжээний өөрчлөлт

3. Борлуулалтын бүлгийн бүтэц, бүлэг доторхи эм барааны бүтэц

4. Үйлчилгээний зорилт

5. Эм барааны ангилал

/101./ Амбулаторийн жороор борлуулах эмийн хэмжээг төлөвлөхөд аль үзүүлэлтийг ашиглах вэ?

1. Амбулаторийн жорын хувь

2. Амбулаторийн үзлэгийн тоо

3. Нэг амбулаторийн жоронд ноогдох үзлэгийн тоо

4. Нэг амбулаторийн жорын дундаж үнэ

5. Нэг амбулаторийн жоронд ноогдох үзлэгийн хувь

/102./ Нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмууд байна. Зөв хувилбаруудыг сонгоно уу?

1. Бие даасан байх зарчим

2. Мөнгөөр хэмжих зарчим буюу тогтвортой мөнгөөр илэрхийлэх зарчим

3. Бодитой байх зарчим

4. Тодорхой байх

5. Хэмжигдэх зарчим

/103./ Жор нь эмийн сангийн ямар үзүүлэлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөхөд хэрэглэгдэх вэ?

1. Эмийн сангийн ажиллах цаг

2. Эмийн сангийн орон тоо

3. ЗТуслах ажилтны тоо

4. Ажлын ачаалал

5. Эмийн нэр төрөл

/104./ Тооллогыг ямар хугацаанд хийх вэ?

1. Замд яваа мөнгө ба бараа, өглөг авлага, зээллэг, татварын албанд орох мөнгөний тооцоог сард нэгээс доошгүй удаа хянах

2. Эмийн сангийн салбар цэгүүдийн тооллогыг сар тутам

3. Мөнгө үнэт цаасны тооллогыг сард нэг удаа

4. Үндсэн хөрөнгө, эд аж ахуйн зүйлийн тооллогыг хагас бүтэн жилээр тоолно

5. Банкан дахь харилцах дансны тооцооны үлдэгдэлийг сар тутам

/105./ Эмийн сангийн эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагааны тайлан балансын „Пассив„ талд дараах асуудлууд тусгагдана.

1. Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл
2. Дүрмийн сан
3. Үндсэн хөрөнгө
4. Ашиг
5. Туслах материал

/106./ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараахь үйл ажиллагааг хориглоно:

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг шуудангийн илгээмжээр явуулах

2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хэрэглэхийг аргачлан заах, тэдгээрийн хууль бус эргэлт, хэрэглээг сурталчилсан кино, дүрс бичлэгт хуурцаг, ном товхимол, хэвлэмэл зургийг нийтэд түгээх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, компьютерийн сүлжээг ашиглан сурталчлах

3. Эмчилгээнд хэрэглэхийг хориглосон мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг худалдах

4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг иргэн Монгол Улсын хилээр нэвтрүүлэх

5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, хүүхдийн бусад байгууллага байрладаг нутаг дэвсгэрт үйлдвэрлэх, худалдах, хадгалах

/107./ Чих ба хамрын дуслын тогтвортой уусмал бэлтгэхийн тулд ямар үйлдлийг хийх вэ?

1. Изотоникжуулна.
2. Тогтворжуулагч нэмнэ.
3. Буферийн уусгагч ашиглана.
4. Ариун нөхцөлд бэлтгэнэ
5. Аагтай уусмал ашиглана.

/108./ Дараах шингэнүүдээс аль нь шокийн эсрэг гемодинамикийн шингэнд хамаарагдах вэ?

1. Аминопептидын уусмал
2. Полиглюкин
3. Рингер-Локкын уусмал
4. Реополиглюкин
5. Гемодез

/109./ Нунтаг эмийн бодисыг холиход хамгийн түрүүнд уурандаа ямар бодисыг эхэлж авах ёстой вэ?

1. Саармаг чанарын бодисыг авна.
2. Саармаг чанарын бодис байхгүй бол их хэмжээтэй бичигдсэн бодисоос авна.
3. Жижиглэхэд бэрхшээлтэй бодисуудыг эхэнд нь авна.
4. Багаас нь их рүү гэсэн зарчмын дагуу хамгийн бага хэмжээтэй бодисыг эхэлж жижиглэнэ.
5. Талст устай бодисуудыг эхлээд авч хатаана.

/110./ Хөвмөл эмийн хэлбэрийг бэлтгэхэд дисперсийн фазын жижиг хэсгийн хэмжээг багасгахад ямар үйлдлийг хийх ёстой вэ?

1. Нунтагийг жижиглэх
2. Нунтаглах процессыг хурдасгадаг шингэн хэрэглэх
3. Шингэн бодисын оролцоотойгоор нунтаглах
4. Жижиг хэсгийг нэгдүүлэх
5. Фазуудын хоорондын таталцлын хүчийг ихэсгэх

/111./ Ханасан уурын даралтын дор автоклаваар ямар зүйлүүдийг ариутгаж болох вэ ?

1. Шил, металл, шаазан эдлэл
2. эмний шил, колбо, юүлүүр, уур, нүдүүр
3. Ороох боох зүйлүүд
4. Өндөр температурт тогтвортой бодисын уусмал
5. пергаментэн цаас, халат, хувцас

/112./ Усан ялгамал бэлтгэхэд хандлах процессын үндсэн үе шатуудад дараах хүчин зүйлүүдээс аль нь хамаарагдах вэ?

1. Түүхий эдийг норгох / капиллярын шингээлт/
2. Хандлалт явуулах
3. ялгамлыг гоожуулж авах
4. Диализ
5. Десорбц

/113./ Цийдмэг эмийн хэлбэрийн давуу талууд:

1. Нэгэн төрлийн байдал
2. Гидрофиль ба липофиль шинж чанартай эмийн бодисуудыг цийдмэгийн найрлаганд оруулах боломжтой
3. Коалесценцийн процесст орох чадвар
4. Дотуур хэрэглэхэд зориулсан цийдмэгээс тос нь хурдан шимэгддэг.
5. Термодинамикийн тогтвортой чанар

/114./ Идээшмэл бэлтгэхдээ

1. Усан халаагуур дээр 15 минут халаана
2. 3.3 л хүртэл хэмжээтэй бол усан халаагуур дээр 25 минут халаана.
3. Тасалгааны температурт 45 минут хөргөнө
4. Усан халаагуур дээр 30 минут халаана.
5. Тасалгааны температурт 10 минут хөргөнө.

/115./ Шингэний дуслын жин ямар хүчин зүйлүүдээс хамаардаг вэ?

1. Дуслын тасарч байгаа талбайгаас хамаарна
2. Даралт ихэсвэл дусал хурдан унах бөгөөд бага хэмжээтэй болдог.
3. Даралт багасвал дуслын жин ихэснэ
4. Дуслын жин нь шингэний хувийн жингээс хамаарна.
5. Дуслын жин нь дусаагуур дотор соруулж авсан шингэний их, багаас хамаарна.

/116./ Усыг нэрэхэд бэлтгэх үйл явцыг заана уу.

1. усыг тунгаах
2. усыг зөөлрүүлэх
3. коллойд хольцыг бүлэгнүүлж ялгах
4. аммиакийг холбож цэвэрлэх
5. органик хольцыг задалж цэвэрлэх

/117./ Усан уусмалыг бэлтгэхэд уусах процессыг хурдасгахад ямар үйлдлийг хийдэггүй вэ?

1. Уусдаг давс үүсгэх процесс
2. Халаах
3. Урьдчилан жижиглэх
4. Хэсэгчилж фракцлах
5. Комплекс нэгдэл үүсгэх

/118./ Хөвмөл хэлбэрийн тосон түрхцэн дэх эмийн бодисын жижиглэлтийн хэмжээг микроскопын тусламжтайгаар тодорхойлоход дараах шаардлагыг хангасан байх ёстой.

1. Германы фармакопейд тосон түрхцэн дэх эмийн бодисын жижиг хэсгийн хэмжээ 60 мкм-ээс томгүй, нүдний тосон түрхцэнд-50 мкм-ээс томгүй байх ёстой.
2. АНУ-д нүдний тосон түрхцэн дэх эмийн бодисын хэмжээ 50 мкм-ээс томгүй байх ёстой.
3. ОХУ-д тосон түрхцэнд 50 мкм-ээс томгүй хэсгүүд 5%-иас хэтрэхгүй байна
4. Босины аргаар тодорхойлоход 60 мкм- ээс томгүй хэсгүүд 5%-иас хэтрэхгүй байна.
5. Чулковын аргаар тодорхойлоход 60 мкм- ээс томгүй хэсгүүд 3%-иас хэтрэхгүй байна

/119./ Үл нийцлийг засах ямар арга замууд байж болох вэ?

1. Эмийн бодисыг тохирох фармакологийн аналогоор нь орлуулах
2. Технологийн онцгой үйлдлийг хэрэглэх
3. Нэг эмийн хэлбэрийг нөгөөгөөр нь солих
4. Үл нийцэл үүсгэж байгаа бодисыг хасах
/19./ Стратегийн менежментийн үйл ажилгаанд аль нь багтах вэ?

1. Дотоод орчны шинжилгээ
2. Гадаад орчны шинжилгээ
3. Стратегийн томъёололт
4. Стратегийн хэрэгжүүлэлт
5. Стратегийн хяналт

/20./ Хяналтын үйл явцад багтах хувилбарыг сонгоно уу?

1. Шаардлагатай мэдээллийг цуглуулах
2. Мэдээллэлд шинжилгээ хийх
3. Үйл ажиллагаа нь төлөвлөлттэй тохирч буйг харьцуулах
4. Хэлбэлзлийг тогтоох
5. Дүгнэлт хийх

/21./ Ямар ч байгууллагын оршин тогтнох үндэс нь юу вэ?

1. Зохион байгуулалт, эрх мэдэл
2. Дотоод орчин

3. Материаллаг үндэс

4. Гадаад орчин

5. Эдийн засаг

/22./ Байгууллагын үйл ажиллагаанд шууд нөлөөлөл үзүүлэх дотоод хүчин зүйлд дараах зүйлийг авч үзнэ :

1. Нийлүүлэгч

2. Улс төрийн бодлого

3. Өрсөлдөгч

4. Бүтэц

5. Шинжлэх ухаан, техник

/23./ Хенри Файолийн тодорхойлсон удирдлагын таван функцид дараах хувилбаруудын аль нь багтах вэ?

1. Төлөвлөх

2. Зохицуулах

3. Хянах

4. Зохион байгуулах

5. Удирдах

/24./ Шийдвэр гаргалтын үе шатуудыг сонгоно уу?

1. Асуудлыг оношлох буюу харьцуулах

2. Шийдвэр гаргах хувилбаруудыг бий болгох

3. Хувилбарыг үнэлэх, сонгох

4. Хамгийн оновчтой хувилбарыг сонгох

5. Шийдвэрээ хэрэгжүүлэх ба үр дүнг тооцох

/25./ Стратегийн төлөвлөлтийн чанарын шалгуурт багтах хувилбарыг сонгоно уу?

1. Өндөр мэргэжлийн удирдлагыг татах чадвар

2. Хэрэглэгчийн үйлчилгээний өргөжилт

3. Учрах аюул саадын багасалт

4. Нөөц боломжийн ашиглалт

5. Зах зээлийн мэдлэгийн сайжралт

/26./ Зохион байгуулалтын бүтцийг дараах хэв маягт хуваана.

1. Функциональ

2. Бүтээгдэхүүнээр хуваах

3. Газар нутгаар бүсчилэх

4. Хэрэглэгчээр хуваах

5. Матриц

/27./ Хяналтын төрлүүдийг сонгоно уу

1. Буцах холбооны хяналт

2. Явцын хяналт

3. Урьдчилсан хяналт

4. Тактикийн хяналт

5. Удирдлагын хяналт

/28./ Бүлгийн шийдвэр гаргалт хэд хэдэн давуу талтай.

1. Хэд хэдэн хүмүүсээс бүрдэх учир мэдээлэл хангалттай цуглуулах боломжтой

2. Асуудал шийдвэрлэх өөр өөр аргыг бий болгодог.

3. Бүлгийн хэлцэл нь оюуны өрсөлдөөн дээр явагддаг тул зөв шийдвэр гарч, үр дүнд хүрдэг.

4. Олон хүн цугладаг тул шийдвэрт хурдан хүрэх боломжтой

5. Үргэлж зөв шийдвэр гардаг.

/29./ Хяналтын функц нь асуудлыг илрүүлэх ба эдгээр асуудлыг хямрал болон даамжирахаас өмнө байгууллагын үйл ажиллагааны хамт засч залруулах боломж олгодог удирдлагын хүчин зүйл юм. Яагаад гэвэл хяналтын системийг боловсруулснаар орчны өөрчлөлтийн талаархи мэдээллийг авч тодорхойгүй байдлыг багасгадаг.

/30./ Бүлгийн гишүүдийн тоог 10-15 хүн байх нь хамгийн тохиромжтой байдаг. Яагаад гэвэл цөөн хүнтэй бүлэгт шийдвэр гарахад хүлээх хувийн хариуцлага өндөр байдаг, олон хүнтэй бүлэгт гишүүд өөрийн санаа бодлоо илэрхийлэхэд хүндрэл үүсч, зөвшилцөхөд илүү бэрх

/31./ Удирдагч нь шийдвэр гаргалтанд ганцаар ноёрхох, бусдын санаа бодлыг зөвшөөрөхгүй байх явдлаас зайлсхийх хэрэгтэй. Яагаад гэвэл бүлгийн гишүүдийн санаа бодлыг урамшуулах нь зөв шийдвэр гаргахад онцгой ач холбогдолтой байдаг.

/32./ Уламжлалт эмийн үйлдвэр үйл ажиллагаанаасаа хамааран дараах тасаг өрөөтэй байна. Үүнд:

1. Уламжлалт тан, үрэл зэхмэл эмийг боох савлах
2. Уламжлалт тан, үрэл зэхмэл эмийг боох савлах
3. Ханд хэлбэрийн бэлдмэл үйлдвэрлэх /хандлах, шүүх, ханд нэрэх, өтгөрүүлэх, савлах, ус нэрэх, шил сав угаах, ариутгах /
4. . Номхотгох буюу дахин боловсруулалт хийх, эмийн ургамал угаах, цэвэрлэх, холтослох үйл ажиллагаа явуулах
5. . Эмт бодис, эцсийн бүтээгдэхүүн, туслах материал хадгалах, эхний материал бэлтгэх, боловсруулах

/33./ Хөдөлмөр зохион байгуулалт, хөдөлмөрийн үйл ажиллагааг дараах аргуудаар судална.

1. Ажлын цагийн зарцуулалтаар судлах
2. Ажиллагсадын өвчлөлийг эмнэлгийн хуудас ба эрүүл мэндийн үзлэгээр судлах
3. Тохиолдлыг ажиглан бүртгэх
4. Шинжилгээний аргууд
5. Ажлын цагийн бүртгэлээр судлах

/34./ Эмийн санд нэвтэрч буй шинжлэх ухааны хөдөлмөр зохион байгууллалтын үр дүн нь дараах үзүүлэлтүүдийн сайжралтаар илэрхийлэгдэнэ

1. Эмийг бэлтгэх хугацааны багасалт
2. Бэлэн хэлбэрийн эмийн эзлэх хувийн ихсэлт
3. Үйлчлүүлэгсэдийн эм авах хүлээлтийн хугацааны багасалт
4. Эмийн нэр төрлийн багасалт
5. Эм бэлтгэх ажилтны тооны ихсэлт

/35./Монгол улсын эмнэлгийн практикт хэрэглэх мансууруулах, сэтгэц нөлөөт болон хүчтэй үйлдэлтэй эмийн жагсаалтын мансууруулах эмийн бүлэгт багтах эмүүдийг сонгоно уу?

1. Галоперидол
2. Трамадол
3. Нитрозепама
4. Петидин
5. Фентазин

/36./ Өвчтөнд олгох эм, биобэлдмэл дараах мэдээллийг агуулсан хаяглалттай байна.

1. Эм, биобэлдмэлийн хүчинтэй байх хугацаа
2. Эм, биобэлдмэлийн нэр
3. Эм, биобэлдмэлийн орос, монгол нэр
4. Хэрэглэх арга
5. Үйлдвэрлэсэн улсын код

/37./ ДЭМБ-аас мөрддөг эм сонголтын шалгуурт доорхи хувилбаруудын аль нь багтах вэ?

1. Эмнэлгийн тусламжийн янз бүрийн түвшинд хэрэглэж болохоор байх
2. Элдэв гаж нөлөө багатай байх
3. Үнэ хямд байх
4. Өвчтөн уух боломжтой байх
5. Улсын бүртгэлд бүртгэгдсэн байх

/38./ Эмнэлгийн эмийн эмчилгээг зохицуулах хороо дараах үүрэг хүлээнэ:

1. Эмнэлгийн эмч, мэргэжилтэн, үйлчлүүлэгчдэд шинэ эм хэрэглэх, эмийн талаар үнэн зөв, бодит мэдээллээр хангах, тэдний эмийн хэрэглээний талаархи мэдлэгийг дээшлүүлэх, сургалт зохион байгуулах;
2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардагдах эмийн жагсаалтыг гаргах, сонголтын талаар зөвлөх;
3. Байгууллагын онцлогт тохирсон эмийн лавлах тогтмол гаргах, эмчилгээний удирдамж (стандарт) боловсруулахад эмч, мэргэжилтэнд туслах;

4. Эмийн гаж нөлөөг бүртгэх, тандах, үнэлгээ өгөх, мэдээлэх, сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

5. Жорын маягт, жор бичилтийн стандартын мөрдөлт, жорын маягтын хангалт, хүртээмж, жор бичилтийг оновчтой болгоход чиглэсэн арга хэмжээ зохион байгуулан, хяналт тавьж ажиллах;

/39./ Үндэсний зайлшгүй шаардлагатай эмэнд хийдэг шинжилгээний аргыг сонгоно уу?

1. АВG шинжилгээ
2. АВС шинжилгээ
3. VЕН шинжилгээ
4. VЕН шинжилгээ
5. VYN шинжилгээ

/40./ Эмийн зохистой хэрэглээнд оролцдог 3-н үндсэн элементийг сонгоно уу?

1. Эмч
2. Өвчтөн
3. Эм зүйч
4. Сувилагч
5. Хүн ам

/41./ Хаягдлыг ялгасны дараа савлах уут, хайрцгийг өнгөөр ялгаж төрөлжүүлнэ. Үүнд:

1. Ердийн хаягдалыг хар өнгийн уут, саванд хийнэ.
2. Эмнэлэг- үйлчилгээний хог хаягдлыг шар өнгийн уут, саванд хийж олон улсын биологийн болон халдвартай хог хаягдлыг таних тэмдгийг тавина.
3. Хими цацраг идэвхитэй, эсэд хортой нөлөө үзүүлдэг хаягдлыг хүрэн өнгийн уут, саванд хийж, тус тусын таних тэмдэг тавина.
4. Халдварын зэрэглэл өндөртэй хаягдлыг цагаан өнгийн уут, саванд хийж халдвартай гэж бичнэ.
5. Щприц зэргийг улаан уутанд хийнэ.

/42./ Эмийн мэдээлэл сурталчилгаа ямар байх ёстой вэ?

1. Үнэн
2. Зөв
3. Бодит
4. Үйлдэл, үр дүнг магтсан
5. Үнэ боломжийн болохыг сурталчилсан

/43./ Эм биобэлдмэлийн жорын ач холбогдол нь юу вэ?

1. Санхүүгийн
2. Хуулийн
3. Анагаах ухааны
4. Эмийн чанарын
5. Эмийн технологийн

/44./ Эмийн хэрэгцээг тодорхойлохдоо нийт эмүүдийг хэд хэдэн бүлэгт хувааж хэрэгцээг тооцож болно. Аль нь зөв вэ?

1. Тасалдалтай байгаа эмүүдийн
2. Өргөн хэрэгцээний эмүүдийн
3. Хэрэглээнд шинээр нэвтэрч байгаа эмүүдийн
4. Мансууруулах, өвөрмэц үйлдэлтэй, нормчлогдсон эмүүдийн
5. Ховор өвчинд хэрэглэгддэг эмүүдийн

/45./ Эмийн санд бэлтгэсэн эмийн бэлдмэл нь эмийн сангийн дараах дотоод хяналт шалгалтанд хамрагдана.

1. Бичгийн
2. Мэдрэхүйн эрхтэний
3. Асуух
4. Зөвхөн амтлах
5. Олгох үеийн хяналт

/46./ Эмийн сан нь Дигоксин тариаг хэрэглэгчдэд хэрхэн олгох вэ?

1. Эмчийн жороор
2. Жоргүйгээр

3. Эмийн санчийн шийдвэрээр

4. Стационарт

5. Өрхийн эмчийн шийдвэрээр

/47./ Аль ч зэрэглэлийн эмийн санд хориглох зүйлүүд :

1. Соёлын болоод гоо сайхны бараа худалдаалах

2. Эмийн хэлбэрүүдийг үйлдвэрлэх

3. Усан уусмал найруулан бэлтгэх

4. Галены бэлдмэл үйлдвэрлэх

5. Бөөн эмийг жижиглэн савлаж худалдаалах

/48./ Иргэний хувийн хэрэглээнд зориулан Монгол улсын хилээр оруулахыг хориглох эмийн нэр төрөл

1. Сүрьеэ эмчлэх эм

2. Антибиотик /тариа/

3. Вакцин

4. Цус сэлбэх шингэн

5. Өнчин эм

/49./ Эмийн санг 3-аас доошгүй жил ажилласан, мэргэшсэн эм зүйч удирдана. Учир нь “Эмийн сангийн стандарт”-д үүнийг заасан байдаг.

/50./ Эмийн сангийн эм найруулах зориулалтын байранд эмчийн жороор стандарт, фармкопейн дагуу эмийг найруулж бэлтгэнэ. Яагаад гэвэл эмийн сан дотоод бэлдмэлийг өөрийн салбараас бусад байгууллагад нийлүүлэхгүй.

/51./ Хугацаа дууссан, хагарч гэмтсэн зэрэг шалтгаанаар хаях эмийн үлдэгдэл хогийг шар өнгийн уутанд цуглуулна. Яагаад гэвэл эмийн сангаас гарах ердийн хог хаягдлыг шар өнгийн тэмдэг бүхий саванд цуглуулдаг.

/52./ Эмийн санд эм шинжлэгчийн ширээг заавал ажиллуулах шаардлагагүй. Учир нь эмийн бүтээгдэхүүний баталгаажуулалт нь үйлдвэрлэгчийн цувралын сертификат болон тохирлын гэрчилгээгээр нотлогдоно.

/53./ Нөөцийн өрөөнд эм барааг төрөлжүүлэн байрлуулна. Учир нь эмийн физик, химийн шинж чанарт тохируулан найдвартай хадгалах нөхцөл хангасан төхөөрөмж бүхий агуулахтай байх ёстой

/54./ Эмийн сангийн ажил олгогч нь ажилтантайгаа ажлын байр, хөдөлмөрийн нөхцөл, гүйцэтгэх ажил үүргийн талаар хөдөлмөрийн гэрээг амаар байгуулна. Яагаад гэвэл ажилтны ажлын байр, гүйцэтгэх ажил үүрэг байнга өөрчлөгдөж байдаг.

/55./ Эмийн сангийн ажиллагсад эрүүл мэндийн үзлэгт жилд нэг удаа хамрагдана. Учир нь ажиллагсад нь халдварт өвчнөөр өвчилсөн, салст үрэвссэн, идээт үрэвсэлтэй байж болохгүй.

/56./ “Х” эмийн сангийн эд хариуцагч А гадаад руу томилтоор яваад ирээгүй байв. Энэ үед тухайн эмийн санд “гэнэтийн ослын” тооллого хийх шаардлага гарав. Ямар шийдвэр гаргах вэ?

А. Ар гэрээс нь хүмүүсийг тооллогод оролцуулна

В. Хууль хяналтын байгууллагын ажилтан ба хөндлөнгийн оролцоотой хийнэ.

С. Тооллогыг комисс дангаараа хийнэ.

Д. Эмийн сангийн эрхлэгч тооллогод оролцоно

Е. Жор баригчийг иртэл нь тооллогыг хүлээнэ

/57./ “Х” эмийн сан жорын төлөвлөлтийг хийхдээ амбулаторийн жорын тоог амбулаторийн үзлэгийн тоонд харьцуулж ямар үзүүлэлтийг тодорхойлж болох вэ?

А. Амбулаторийн үзлэгийг тооцох коэффициент

В. Амбулаторийн жорын төлөвлөлтийн коэффициент

С. Амбулаторийн үзлэгийн төлөвлөлтийн коэффициент

Д. Амбулаторийн жор ба төлөвлөлтийг тооцох коэффициент

Е. Амбулаторийн жорыг тооцох коэффициент

/58./ “Х” эмийн сан стационарын жорын төлөвлөлтийг хийхэд жилийн ор хоногийг тооцох шаардлага гарчээ. Дараах хувилбаруудын аль зөв бэ?

А. Жилийн ор хоног = эмнэлгийн орны тоо х ор хоног

- В. Жилийн ор хоног = Төлөвлөсөн ор хоног х эмнэлгийн орны тоо
- С. Жилийн ор хоног = эмнэлгийн орны тоо х жилд ашиглах ор өдөр
- Д. Жилийн ор хоног = жилийн өдөр х эмнэлгийн орны тоо
- Е. Жилийн ор хоног = эмнэлгийн орны тоо х ор хоногийн коэффициент

/59./ “Х” эмийн сан жорын стационарын жорын төлөвлөлтийг хийхэд стационарын жорыг тооцох коэффициентыг тооцох шаардлага гаржээ. Дараах хувилбаруудын аль зөв бэ?

- А. Стационарын жорыг тооцох коэффициент = стационарын үзлэгийн тоо / жилийн ор хоног ашиглалт
- В. Стационарын жорыг тооцох коэффициент = жилийн ор хоног ашиглалт/ стационарын жорын тоо
- С. Стационарын жорыг тооцох коэффициент = стационарын жорын тоо / жилийн ор хоногийн тоо
- Д. Стационарын жорыг тооцох коэффициент = стационарын жорын тоо / жилийн ор хоног ашиглалт
- Е. Стационарын жорыг тооцох коэффициент = жилийн ор хоногийн тоо/ стационарын жорын тоо

/60./ Шинээр эмийн сан нээж ажиллуулах тохиолдолд жорын төлөвлөгөөг хэрхэн хийх вэ?

- А. жорыг тэр эмийн сантай ойрхон байгаа дүүргийн хүн ам, эмчийн тоо зэрэг бусад үзүүлэлттэй амбулаторийн жорын тоог үндэслэн төлөвлөж болно.
- В. жорыг тэр эмийн сантай зэрэгцээ байгаа дүүргийн хүн ам, эмчийн тоо зэрэг бусад үзүүлэлттэй амбулаторийн жорын (1 амбулаторийн үзлэгт ноогдох жорын коэффициент) тоог үндэслэн төлөвлөж болно.
- С. жорыг тухайн эмийн сангийн үйлчлэх хүн ам, эмчийн тоо зэрэг бусад үзүүлэлттэй амбулаторийн жорын (1 амбулаторийн үзлэгт ноогдох жорын коэффициент) тоог үндэслэн төлөвлөж болно.
- Д. жорыг тухайн эмийн сангийн үйлчлэх хүн ам, эмчийн тоо зэрэг бусад үзүүлэлттэй амбулаторийн жортой харьцуулж төлөвлөж болно.
- Е. жорыг тухайн эмийн сангийн үйлчлэх хүн ам, эмч, эмийн сангийн тоо зэрэг бусад үзүүлэлттэй амбулаторийн жорын (1 амбулаторийн үзлэгт ноогдох жорын коэффициент) тоог үндэслэн төлөвлөж болно.

/61./ “Х” эмийн сан амбулаторийн жорын борлуулалтыг тооцжээ. Дараах хувилбаруудын аль нь зөв вэ?

- А. Амбулаторийн жорын тоог 1 амбулаторийн жорын үнээр үржүүлж
- В. Амбулаторийн жорын тоог 1 амбулаторийн жорын үнэд харьцуулж
- С. Амбулаторийн жорын тоог амбулаторийн үзлэгийн тоогоор үржүүлж
- Д. Амбулаторийн жорын тоог амбулаторын үзлэгээр үржүүлж, 1 амбулаторийн жорын үнэд харьцуулж
- Е. Амбулаторийн жорын тоог 1 амбулаторийн жорын үнээр үржүүлж, үзлэгийн тоонд харьцуулж

/62./ Эмийн сангийн эргэлтийн хөрөнгийн нөөцийн эзлэх хувь нь ямар байвал зохимжтой вэ?

- А. Дөрөвний гурав нь байвал
- В. Дөрөвний хоёр нь байвал
- С. Гуравны хоёр нь байвал
- Д. Аравны найм нь байвал
- Е. Хоёрны нэг нь байвал

/63./ Эмийн нөөцийн эргэлтийн хурд удаан байвал ашиг ямар байх вэ?

- А. Нөлөөлөхгүй
- В. Нөлөөлнө
- С. Бага зэрэг нөлөөтэй
- Д. Төдий чинээ сайн байна
- Е. Төдий чинээ муу байна

/64./ Аливаа эмийн сангуудын барааны эргэлтийн хурд нь барааны нөөцөөс ихээхэн хамаарах ба борлуулалтын хэмжээтэй ямар хамааралтай байх вэ?

- А. Бага зэрэг хамааралтай

- В. Нилээд хамааралтай
- С. Урвуу хамааралтай
- Д. Шууд хамааралтай
- Е. Хамааралгүй

/65./ Эмийн эргэлт удааширсан ч хэмжээ нь их байвал эргэлтийн хөрөнгийн хөдөлгөөн яах вэ?

- А. Түргэснэ.
- В. Орлого ихсэнэ.
- С. Нэмэгдэнэ.
- Д. Зогсонги байдалтай болно.
- Е. Орлого буурна.

/66./ “Х” эмийн сангийн худалдааны орлогыг тооцон үзжээ. Дараах хувилбаруудын алийг сонгож бодох вэ?

- А. Худалдааны орлого=Үнэ(жижиглэнгийн)–Үнэ(бөөний)
- В. Худалдааны орлого=Үнэ(жиж.)–Үнэ(бөөний) Зардал
- С. Худалдааны орлого=Ашиг–Зардал
- Д. Худалдааны орлого=Үнэ (бөөний)–Үнэ (жижиглэнгийн)
- Е. Худалдааны орлого=Үнэ(жижиглэнгийн)–Үнэ

/67./ Клиникийн эмнэлгийн эмийн сан нь стационарын жорын төлөвлөгөөг хийжээ. Дараах хувилбаруудын аль сонголтыг ашиглах вэ?

А. Клиникийн эмнэлгийн эмийн сан нь стационарын жорын төлөвлөгөөг хийжээ. Дараах хувилбаруудын аль сонголтыг ашиглах вэ?

В. Стационарын жорын борлуулалт = Стационарын жорын тоо х 1 стационарын жорын үнэ

С. Стационарын жорын борлуулалт = Стационарын жорын тоо х Жилд ашиглах орны тоо

Д. Стационарын жорын борлуулалт = Стационарын орны тоо х 1 стационарын жорын үнэ

Е. Стационарын жорын борлуулалт = Ор хоног х хэвтэн эмчлүүлэгсэдийн тоо

/68./ Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт шинээр нийтийн үйлчилгээтэй эмийн сан нээв. Эм бараа борлуулалтыг ашиглан нийт ажилчдийн тоог хэрхэн тооцох вэ? (Борлуулалтыг мян/ төг-өөр авна)

- А. Нийт ажилчдын тоо = $2.5 + 0,005 \text{ ЭББ/бөөний үнээр/} + 0,02 \text{ ЭББ/жижиглэнгийн үнээр/}$
- В. Нийт ажилчдын тоо = $2,4 + 0,005 \text{ ЭББ/бөөний үнээр/} + 0,03 \text{ ЭББ/жижиглэнгийн үнээр/}$
- С. Нийт ажилчдын тоо = $2,4 + 0,005 \text{ ЭББ/бөөний үнээр/} + 0,02 \text{ ЭББ/жижиглэнгийн үнээр/}$
- Д. Нийт ажилчдын тоо = $2,4 + 0,006 \text{ ЭББ/бөөний үнээр/} + 0,02 \text{ ЭББ/жижиглэнгийн үнээр/}$
- Е. Нийт ажилчдын тоо = $2.4 + 0,005 \text{ ЭББ/бөөний үнээр/} + 0.2 \text{ ЭББ/жижиглэнгийн үнээр/}$

/69./ “Х” эм ханган нийлүүлэх байгуулах байгууллага өнгөрсөн оны ашигаа тодорхойлжээ. Ашгийг хэрхэн олох вэ?

- А. Худалдааны орлогын дүнгээс зардлын дүнг хасаж
- В. Худалдааны ашгийн дүнгээс зардлын дүнг хасаж
- С. Худалдааны ашгийг зардлын дүнд харьцуулж
- Д. Худалдааны ашгийг зардлын дүнд үржүүлж
- Е. Худалдааны ашгийг зардлаар үржүүлж 100-д хувааж

/70./ Тоологдоор эд хариуцагчийн эм бараанаас хагарч хэмхэрсэн, ширгэсэн, чанар байдал нь муудсан, хугацаа дууссан эм бараа гарвал ямар шийдвэр гаргах вэ?

- А. Тоологдсон зүйлийн ерөнхий дүнгээс хасна.
- В. Тоологдсон зүйлийн ерөнхий дүнгээс хасаж, тусгай бүлгээр бүртгэл үйлдэнэ.
- С. Тоологдсон зүйлийн ерөнхий дүнд оруулан тусгай бүлгээр бүртгэл үйлдэнэ
- Д. Тоологдсон зүйлийн ерөнхий дүнгээс хасаж, оруулан тусгай бүлгээр бүртгэл үйлдэнэ
- Е. Тоологдсон зүйлийн ерөнхий дүнд оруулан актална.

/71./ Нягтлан бодох бүртгэл нь байгууллагын удидлагыг шийдвэр гаргахад онцгой ач холбогдолтой. Учир нь эдийн засгийн тоон мэдээллийг танин мэдэж, мөнгөн нэгжээр

тооцон хэмжиж, шинжлэн боловсруулж дүгнэлт, шийдвэр гаргах боломжоор хангадаг мэдээллийн систем юм.

/72./ Орлого гэдэг нь бизнесийн нэгжийн худалдан борлуулсан бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил үйлчилгээний үнэ бөгөөд байгууллагын өсөлтийг хангадаг нэг чухал үзүүлэлт юм. Учир нь байгууллагуудын капиталыг нэмэгдүүлэх үндэс болно.

/73./ Зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгэснээр зардлын хэтрэлтэд хяналт тавих, орлого зардлыг харьцуулах, ашгийг хэмжих, мөн цаашдын төлөвлөгөө, төсөл зохиох судалгаа-шинжилгээ хийх, удирдлагын оновчтой шийдвэр гаргах зэрэгт онцгой ач холбогдолтой. Учир нь харин зардал бол борлуулсан бараа, үзүүлсэн үйлчилгээний өртөг болно.

/74./ Хөрөнгө нь балансын тэнцэтгэлийн зүүн гар талд байрладаг. Яагаад гэвэл үүнтэй уялдан хөрөнгийн бүх дансуудын зүүн буюу дебет талд нэмэгдэх өөрчлөлтийг баруун буюу кредит талд хорогдох өөрчлөлтийг тусгадаг.

/75./ Тооллогоор бүх хөрөнгө бараа материал нэг бүрчлэн тоологдож, хэмжигдэж, нүд үзэн тоолох хэрэгтэй. Яагаад гэвэл бөөнөөр савлагдсан баглаа боодолтой эм бараа задлагдсан байж болно

/76./ Эмийн сангийн хүлээн авах жор нь тоогоор болон мөнгөн хэлбэрээр төлөвлөгдөнө. Яагаад гэвэл жор нь эмийн сангийн орон тоо, туслах материалын зардал, ажлын ачаалал, зэрэглэл зэрэг эмийн сангийн эдийн засгийн үзүүлэлтүүдийг төлөвлөхөд хэрэглэгдэнэ.

/77./ Эмийн нөөц байнгын эргэлтэнд орж, түүний хурд хэдий чинээ сайн байна, эмийн хангамж, орлого ашиг төдий чинээ сайн байна. Яагаад гэвэл эмийн сангийн эргэлтийн хөрөнгийн гуравны хоёр нь барааны нөөц байна.

/78./ Барааны хөдөлгөөний хурд, нөөцийн хэмжээ нь хоорондоо шууд хамааралтай байна. Яагаад гэвэл бараа хэдий чинээ хурдан хөдөлгөөнд орно, барааны нөөцийн хэмжээ /хоногоор/ төдий чинээ багасана.

/79./ Тодорхой барааг авахад зарим хөнгөлөлт үзүүлэх, ердийн үнээс доогуур үнээр барааг худалдах, үнийн хорогдол тооцох, төрөлжсөн үзэсгэлэн гаргах, судалгаа явуулах зэрэг нь урамшлын иж бүрдэлийн ямар хэрэгсэлд багтах вэ?

- A. Зар сурталчилгаа
- B. Мэдээлэл сурталчилгаа
- C. Борлуулалтын урамшуулал
- D. Борлуулалтын эргэлт
- E. Худалдааны хөнгөлөлт

/80./ Бараа, үйлчилгээний нийлүүлэлт, эрэлт 2 хоорондоо харилцан тэнцэж байгаа байдлыг маркетингийн ухааны үүднээс юу гэж ойлгох вэ?

- A. Эрэлтийн хангалт
- B. Зах зээлийн тогтворжилт
- C. Зах зээлийн тэнцвэр
- D. Хэрэгцээний хангалт
- E. Маркетингийн тооцоо

/81./ Эдийн засгийн мөн чанарыг тодорхойлох үг

- A. Нөөц
- B. Хэрэгцээ
- C. Ховор хомс нөөц
- D. Капитал
- E. Байгалийн нөөц

/82./ Хүний хэрэгцээ:

- A. Хязгаарлагдмал
- B. Хязгааргүй
- C. Хялбар хангагддаг
- D. Тухайн нийгмийн хүчин чадалтай тэнцүү
- E. Хэмжээтэй

/83./ Орлого өсөхөд дагалдах барааны эрэлт:

- A. өснө
- B. буурна

- C. хэвээрээ
 - D. тодорхойлох боломжгүй
 - E. Өргөн хэрэглээний бараанд өснө
- /84./ Барааг худалдан авах үйл ажиллагааг нэмэгдүүлэн урамшуулах маркетингийн урамшууллын иж бүрдэлийн нэг нь :
- A. зарлал чимэглэл
 - B. борлуулалтын урамшуулал
 - C. ухуулга
 - D. биечлэн хийх худалдаа
 - E. биечлэн хийх худалдаа
- /85./ Сануулах чиглэлийн зарлал чимэглэлийг барааны амьдралын мөчлөгийн аль шатанд хийх нь зүйтэй вэ?
- A. зах зээлд гарах
 - B. зах зээлд боловсрох
 - C. зах зээлд өсөх
 - D. зах зээлд унах
 - E. зах зээлд өрсөлдөх
- /86./ Мэдээлэл өгөх чиглэлийн зарлал чимэглэлийг
- A. зах зээлд гарах
 - B. зах зээлд боловсрох
 - C. зах зээлд өсөх
 - D. зах зээлд унах
 - E. зах зээлд өрсөлдөх шатанд явуулах нь зүйтэй
- /87./ Маркетингийн төлөвлөлтийн суурь нь:
- A. үйл ажиллагааны төлөвлөлт
 - B. бүтцийн төлөвлөлт
 - C. бодлогын төлөвлөлт
 - D. ашгийн төлөвлөлт
 - E. хүн хүчний төлөвлөлт юм.
- /88./ Хүмүүсийн хэрэгцээг хангахуйц олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хийхэд шаардлагатай төрөл бүрийн хүчин зүйлсийг хооронд нэгтгэх үйл явцыг
- A. хөдөлмөр
 - B. капитал
 - C. бүтээгдэхүүн
 - D. үйлдвэрлэл
 - E. үйлчилгээ гэнэ.
- /89./ Байгууллага, хүний эрэлттэй бүтээгдэхүүн, үйлчилгээг бизнесийн хэвшил нийлүүлж, хариуд нь төлбөр авах үйл ажиллагааг маркетингийн ойлголтоор
- A. хүчин зүйлсийн зах зээл
 - B. үйлвэрлэлийн зах зээл
 - C. бүтээгдэхүүний зах зээл
 - D. улсын байгууллагын зах зээл
 - E. хэрэглэгчдийн зах зээл
- /90./ Зах зээлийн үнийн өрсөлдөөнт тогтцыг:
- A. чөлөөт зах зээлийн эдийн засаг
 - B. үнийн уян хатан байдал
 - C. үнэ тогтворжилт
 - D. ялгаварт үнийн систем
 - E. үл ялгаварт үнийн тогтолцоо гэнэ
- /91./ Эдийн засгийн ажиллагаанд татварын ба улсын зарлагын аргаар нөлөөлөх төрийн үйлдлийг
- A. төрийн бодлого
 - B. төрийн зохицуулалт
 - C. татварын бодлого
 - D. эдийн засгийн бодлого

- Е. сангийн бодлого
- /92./ Хүмүүсийн ямар нэгэн зүйл төлбөр хийх хүсэл ба чадварыг илэрхийлдэг нэр томъёо аль нь вэ?
- А. Хэрэгцээ
 - В. Эрэлт
 - С. Шаардлага
 - Д. Хүсэл
 - Е. Сонирхол
- /93./ Барааны үнийн бууралтын шалтгаан нь:
- А. Татварын өсөлт
 - В. Хэрэглэгчийн орлогын өсөлт
 - С. үйлдвэрлэлийн нөөцийн үнийн бууралт
 - Д. дагалдах барааны үнэ цэнийн бууралт
 - Е. Экспортын татварын бууралт
- /94./ Чөлөөт зах зээл дээр борлуулалт бууралтын хэмжээг юу тодорхойлдог вэ?
- А. Засгийн газар
 - В. Эрэлт нийлүүлэлтийн хэмжээний нийлбэр
 - С. Эрэлт нийлүүлэлтийн хэмжээний ялгавар
 - Д. Эрэлт нийлүүлэлтийн хэмжээний аль их нь
 - Е. Эрэлт нийлүүлэлтийн хэмжээний аль бага нь
- /95./ Хомсдол гэж юу вэ?
- А. үйлдвэрлэлийн хэмжээ буурах
 - В. хүмүүсийн хэрэгцээт бараа дутагдалтай байх
 - С. эрэлтийн хэмжээ нийлүүлэлтийн хэмжээнээс их байх
 - Д. нийлүүлэлтийн хэмжээ багасах
 - Е. гачигдал нь хангагдаагүй байх
- /96./ Үнийн доод түвшинг тогтоосноор:
- А. Хомсдлыг бий болгоно
 - В. Эрэлтийг нэмэгдүүлнэ
 - С. Нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ
 - Д. Эрэлт нийлүүлэлт хэвээр байна
 - Е. Борлуулалтыг нэмэгдүүлнэ
- /97./ Үнийн түвшин өөрчлөгдсөнөөс
- А. Нийлүүлэлт өөрчлөгдөнө
 - В. Нийлүүлэлтийн хэмжээ өөрчлөгдөнө
 - С. Нийлүүлэлт хэвээр байна
 - Д. Нийлүүлэлтийн хэмжээ өөрчлөгдөхгүй
 - Е. Эрэлт өөрчлөгдөнө
- /98./ Эрэлтийн хууль
- А. Эрэлтээс нийлүүлэлт давсан үед үнэ буурна
 - В. Хэрэглэгчийн орлого өсөхийн хэрээр худалдаж авах барааны хэмжээ нэмэгдэнэ
 - С. Барааны үнэ буурахад худалдан авах хэмжээ нь нэмэгдэхийг харуулна
 - Д. Зар сурталчилгаа нь худалдааг эрчимжүүлнэ
 - Е. Бичэгдсэн хууль байхгүй
- /99./ Эрэлтийн мэдрэмж муутай барааны үнэ өсөхөд нийт орлого:
- А. Өснө
 - В. Буурна
 - С. Тогтмол
 - Д. Хамааралгүй
 - Е. Бага зэрэг өснө
- /100./ Зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрлийн 20%-ийг эзэлдэг эмүүдийг А ангилалд хамааруулна учир нь уг эмүүд хямд үнэтэй тул их хэмжээгээр захиалан авч болно.

/101./ Нэгж бүтээгдэхүүний үнийг багасгахад нийт орлого буурна, яагаад гэвэл үнийг ихэсгэхэд нийт орлого буурч эрэлтийн мэдрэмж муу байна гэж үзнэ.

/102./ Барааны үнэ нь эрэлттэй шууд хамааралтай байна учир нь үнэ өндөр бол эрэлт бага, үнэ бага бол эрэлт өндөр байна.

/103./ Цэвэр өрсөлдөөний зах зээлийн нөхцөлд эм үйлдвэрлэгч өөрийн үйлдвэрлэсэн эмийн үнийг зах зээлийн үнээс өндөр тогтоож чаддаггүй. Учир нь худалдан авагч нь уг эмийг аль ч эм үйлдвэрлэгчээс зах зээлийн үнээр авах бололцоотой байдаг.

/104./ Эмчилгээний зориулалттай хийг хэрэглэж дуусахад баллон даралтгүй болдог. Ийм учраас тээвэрлэх үед цэнэгтэй баллон тээвэрлэхтэй адил нөхцөл шаардлагагүй бөгөөд хамгаалах таг, хажуугийн бөглөө заавал байх албагүй.

/105./ Эмнэлгийн эмийн эмчилгээний хороо нь эмнэлгийн даргаар батлуулсан ажлын нарийвчилсан төлөвлөгөөтэй ажилладаг. Учир нь хорооны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг эмнэлгийн байгууллага төсөвтөө тусган санхүүжүүлнэ.

/106./ Тээвэрлэлт хадгалалтын онцгой горим шаардагдах вакцин, биобэлдмэл, оношлуур байдаг бөгөөд тэдгээрээс бусад барааг гаалийн агуулахаас татан авах үүргийг Эмимпэкс концерн хариуцах ба харин вакцин, биобэлдмэл, оношлуурын татан авалт, хадгалалт, тээвэрлэлтийг ХӨСҮТ гүйцэтгэнэ.

/107./ Гэмт хэрэг зөрчлийн улмаас эрүүл мэндэд нь гэм хор учирсан даатгуулагчийн тусламж үйлчилгээний зардлын төлбөрийг гэм хор учруулсан буруутай этгээдээр төлүүлнэ. Учир нь даатгагч нь эрүүл мэндийн байгууллагад төлөх төлбөрөө 14-с дээш хоногоор хугацаа хожимдуулсан бол уг төлбөрийг нөхөн төлүүлж, хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.1%-тай тэнцэх алданги тооцно.

/108./ Даатгуулагчид олгох эм нь тухайн эмийн санд ерөнхий нэршлээр байхгүй үед худалдааны нэрээр орлуулан олгож болно. Энэ тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан үнийг даатгалын сангаас нөхөн төлөхгүй.

/109./ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийг эмчилгээний зорилгоор ашиглэх журам, нөхцлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Хуульд өөрөөр заагаагүй бол мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх худалдах журмыг тогтоохдоо Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн заалтыг баримтална.

/110./ Тарилгын уусмал ба нүдний дуслыг шүүхэд хэрэглэдэг шилэн шүүлтүүрийн хэмжээг заана уу.

- A. нүхний голч нь 90-120 мкм
- B. нүхний голч нь 120-150 мкм
- C. нүхний голч нь 40-90 мкм
- D. нүхний голч нь 5-40 мкм
- E. нүхний голч нь 150-200 мкм

/111./ Хөвөн ба самбайн оронд хэрэглэдэг шилэн шүүлтүүрийн хэмжээг заана уу.

- A. нүхний голч нь 90-120 мкм
- B. нүхний голч нь 150-200 мкм
- C. нүхний голч нь 40-150 мкм
- D. нүхний голч нь 5-15 мкм
- E. нүхний голч нь 15-40 мкм

/112./ 1 гр бодисын уусахад 1 мл хүртэл уусгагч шаардагддаг бол тухайн бодис уусалтаараа ямар ангилалд хамаарагдах вэ?

- A. Маш амархан уусдаг
- B. Амархан уусдаг
- C. Уусдаг
- D. Аажим уусдаг
- E. Маш муу уусдаг

/113./ №1 уур нүдүүрийн диаметр (мм) -ийг заана уу?

- A. 40 мм
- B. 50 мм
- C. 55 мм
- D. 60 мм

Е. 65 мм

/114./ Холимог шингэн эмийн нэг удаагийн болон хоногийн тунг шалгана уу?

Rp: Infusi herb. Thermopsideis 0.5-200ml

Natrii hydrocarbonatis

Liquoris Ammonii anisati аа 4.0.

M.D.S. Хоолны халбагаар өдөрт 3 удаа ууна.

Холимог шингэн эмийн нэг удаагийн болон хоногийн тунг шалгана уу?

А. нэг удаагийн тун 0.038, хоногийн тун 0.11

В. нэг удаагийн тун 0.038, хоногийн тун 0.08

С. нэг удаагийн тун 0.012, хоногийн тун 0.02

Д. нэг удаагийн тун 0.012, хоногийн тун 0.03

Е. нэг удаагийн тун 0.025, хоногийн тун 0.07

/115./ Нийлмэл найрлагатай эмийн бэлдмэлийг бэлтгэхэд үүсч болох физик химийн ба химийн зохисгүй процессууд нь ямар шалтгааны дүнд бий болдог вэ?

1. жорон дахь ингредиентүүдийн тоон харьцаагаар

2. фармакологийн антогонизмаар

3. орчны рН- аар

4. бэлтгэх аргаар

5. Орчны зуурамтгай чанараас

/116./ Үрэлд ямар зорилгоор туслах бодисуудыг нэмдэг вэ?

1. үрэл эмэнд жин багтаамж олгох зорилгоор

2. үрэлд уян хатан байдал олгох зорилгоор

3. үрэлд хэлбэр дүрс олгох зорилгоор

4. үрэл эмийн бүрэлдэхүүнд орж байгаа эмийн бодисын үйлчилгээг ихэсгэх зорилгоор

5. үрэл эмийн бүрэлдэхүүнд орж байгаа эмийн бодисын үйлчилгээг хурдасгах зорилгоор

/117./ Жин –эзэлхүүний аргаар ямар уусмалуудыг бэлтгэдэг вэ?

1. Усан уусмал

2. Спиртэн уусмал

3. Коллойд уусмал

4. Тосон уусмал

5. Жоронд уламжлалт нэрээр бичигдсэн стандарт шингэн

/118./ Өндөр молекулт нэгдэл ба хамгаалагдсан коллойд уусмалыг бэлтгэхэд тэдгээрийн хоёуланд нь байдаг ямар нийтлэг шинж чанарыг тооцох шаардлагатай вэ?

1. Молекулын хэмжээ том байдаг

2. Электролит сөргөөр нөлөөлдөг

3. Дисперсийн системийн төрөл

4. Диффузын хурд бага

5. Зуурамтгай чанар нь өндөр байдаг.

/119./ Хариулт буруу

Усан уусмалыг бэлтгэхэд уусах процессыг хурдасгахад ямар үйлдлийг хийдэггүй вэ?

1. Уусдаг давс үүсгэх процесс

2. Халаах

3. Урьдчилан жижиглэх

4. Хэсэгчилж фракцлах

5. Комплекс нэгдэл үүсгэх

/120./ Хариулт буруу

Усан ба спиртэн уусмал бэлтгэх ерөнхий технологийн дүрмэнд аль арга нь хамаарах вэ?

1. Жин эзэлхүүний арга

2. Халаах, шүүх

3. Уусгагчийг эзэлхүүнээр хэмжиж авах арга

4. Эмийн бодисыг жигнэж авсныхаа дараа уусгагчийг нэмэх

5. Хуурай ариутгасан шилэнд уусгах процессыг явуулна.

/121./ Зуурамтгай шинж чанартай уусгагч бүхий уусмалыг бэлтгэх ямар онцлог байдаг вэ?

1. Жингийн аргаар бэлтгэх

2. Ариутгасан хуурай олгох шилэнд халаах замаар уусгана.
3. Шаардлагатай бол хоёр давхар самбайгаар шүүнэ.
4. Жин-эзэлхүүний аргаар бэлтгэх
5. Халаах шаардлага гардаг учир хуурай шилэнд уусгана.

/122./ Хөвмөл эмийн хэлбэрийг бэлтгэхэд дисперсийн фазын жижиг хэсгийн хэмжээг багасгахад ямар үйлдлийг хийх ёстой вэ?

1. Нунтагийг жижиглэх
2. Нунтаглах процессыг хурдасгадаг шингэн хэрэглэх
3. Шингэн бодисын оролцоотойгоор нунтаглах
4. Жижиг хэсгийг нэгдүүлэх
5. Фазуудын хоорондын таталцлын хүчийг ихэсгэх

/123./ Дараах ямар тохиолдолд конденсацын арга нь хөвмөл эмийн хэлбэрийг бэлтгэхэд хэрэглэгддэг вэ?

1. Дисперсийн орчинд эмийн бодис нь уусахгүй тохиолдолд
2. Уусгагчийг солих
3. Уусалтыг сайжруулах
4. Химийн урвалын үр дүнд тунадас үүсэх
5. Коалесценц

/124./ Цийдмэг эмийн хэлбэрийн давуу талууд:

1. Нэгэн төрлийн байдал
2. Гидрофиль ба липофиль шинж чанартай эмийн бодисуудыг цийдмэгийн найрлаганд оруулах боломжтой
3. Коалесценцийн процесст орох чадвар
4. Дотуур хэрэглэхэд зориулсан цийдмэгээс тос нь хурдан шимэгддэг
5. Термодинамикийн тогтвортой чанар

/125./ Хэрэв жоронд тосон түрхэцийн суурийг заагаагүй ба техникийн баримт бичигт тосон түрхэцийн найрлага нь байхгүй байх тохиолдолд суурийг сонгож авахдаа юуг тооцох ёстой вэ?

1. Тосон түрхэцийн хэрэглэх зориулалтаар
2. Дисперсийн системийн төрөл
3. Эмийн бодисуудын физик химийн шинж чанар
4. Эмийн бодисын хэмжээ
5. Эмийн бодисын усанд уусах чанар

/126./ Тосон түрхэцээс эмийн бодис шимэгдэх процессыг сайжруулах сууринд ямар суурь хамаарагддаг вэ?

1. Вазелин
2. Ланолин ургамлын тостой холимог
3. Силиконон суурь
4. Констентны эмульсэн суурь ус/ вазелин
5. Загасан тос

/127./ Лааны сууринд тосон түрхэцийн сууриас ялгагдах ямар өвөрмөц шаардлагууд тавигддаг вэ?

1. Биеийн температурт уусдаг.
2. Биеийн температурт хайлдаг.
3. Тасалгааны температурт хатуу
4. Эмийн бодисыг хурдан чөлөөлдөг
5. Зөөлөн консестенцтэй байх

/128./ Фармакопейн заалтын дагуу лааны чанарыг ямар шалгуураар шалгадаг вэ?

1. Уусах хугацаа
2. Нэгэн төрөл
3. Задралт
4. Деформацид бүрэн орох хугацаа
5. Лааны жингийн хэлбэлзэл

/129./ Үл нийцлийг засах ямар арга замууд байж болох вэ?

1. Эмийн бодисыг тохирох фармакологийн аналогоор нь

2. Технологийн онцгой үйлдлийг хэрэглэх
3. Нэг эмийн хэлбэрийг нөгөөгөөр нь солих
4. Үл нийцэл үүсгэж байгаа бодисыг хасах
5. Жорноос А ба Б дансны бодисыг тусад нь олгох

/130./ Ургамлын түүхий эдээс үйлчлэгч бодисыг бүрэн гүйцэд хандлахад юу нөлөөлдөг вэ?

1. Түүхий эд экстрагентын харьцаа
2. Диффузын процессын хурд
3. Хандлах дэглэм
4. Усан ялгамлын эзэлхүүн
5. Экстракт-концентратын эзэлхүүн

/131./ Ургамлын түүхий эдээс усан ялгамал бэлтгэхэд ямар шинж чанарыг тооцох ёстой вэ?

1. Түүхий эдийн эсийн бүтэц
2. Үйлчлэгч бодисын физик химийн шинж чанар
3. Дагалдагч болон балласт бодисын физик химийн шинж чанар
4. Шүүх арга
5. Экстрагентын эзэлхүүн

/132./ Асуулт буруу

Эмийн сангийн нөхцөлд тарилгын уусмал бэлтгэх технологт аль нь хамаарах вэ?

1. Эмийн бодисыг уусгаж уусмал бэлтгэх
2. Уусмалыг шүүж, механик хольцыг шалгах
3. Шилийг бөглөж хаяглах
4. Уусмалыг ариутгах
5. Уусмалын чанарыг шалгаж бэлэн болгох

/133./ Хүчтэй суурь, сул хүчлийн үлдэгдлээс тогтсон эмийн бодисыг тогтворжуулахад хэрэглэгддэг бодисыг заах

1. Давсны хүчил
2. Натрийн шүлт
3. Вейбелийн тогтворжуулагч
4. Натрийн гидрокарбонат
5. Этилендиаминтетра-цууны хүчил

/134./ Ургамлын түүхий эдээс усан ялгамал бэлтгэх нь экстракт концентраатаас бэлтгэснээс илүү сайн чанартай байдаг. Яагаад гэвэл үйлчлэгч бодис нь гүйцэд ялгардаг.

/135./ Уусгагчийг сонгон авахдаа «төстэй зүйл төстөйдөө» уусна гэсэн дүрмийг баримтална. Иймээс ямар нэгэн бодисыг уусгахад түүнтэй бүтцээрээ ойролцоо уусгагчийг авна.

/136./ Этанолын концентрацыг сулруулахад холимгийн температур нэмэгдэж эзэлхүүн нь багасдаг. Яагаад гэвэл контракцын үзэгдэл явагддаг.

/137./ Хөвмөлийн дисперсийн фаз нь шингэн дотор үргэлж хөвж байж чаддаггүй. Учир нь таталцах хүчний нөлөөгөөр сидментацад ордог.

/138./ Коллойд уусмал нь дисперсийн фазынхаа ширхэгийн хэмжээгээрээ хөвмөл ба жинхэнэ уусмал хоёрын хооронд байрлана. Иймээс нэвтэрч буй гэрэлд булингартай, ойж буй гэрэлд тунгалаг харагддаг нэгэн төрлийн биш систем юм.

/139./ Камфор, фенилсалицилат, терпингидрат, ментол зэрэг устай үл нийцдэг бодисуудыг устай нийцдэг бодисуудтай урьдчилан холино. Учир нь эдгээр нь устай нийцдэггүй

/140./ Жинтэй ажиллахдаа туухай ба жигнэх зүйлийг тавгийн голд тавина. Яагаад гэвэл жингийн зүүн тавган дээр туухайг, баруун тавган дээр эмийн бодисыг хийж жигнэнэ.

/141./ Халууруулах бодис гэдэг нь бичил биетний амьдралын явцад үүссэн уураг болон полисахаридууд юм. Халууруулах бодис нь дэгдэмхий учир усны ууртай хамт нэрэгдэж, усны дусалтай хамт хөргөгчинд орж болох аюултай.

/142./ Хариулт буруу Эмийн сангийн практикт гадуур хэрэглэгдэх зарим шингэн эмийн хэлбэрийг бэлтгэхэд дэгдэмхий ба дэгдэмхий биш уусгагчийг хэрэглэнэ. Эдгээр уусгагчидад найруулсан уусмалыг усан биш уусмал гэх ба ихэвчлэн хамар чихний дусал,

тосон түрхэц, шингэн тос байдалтайгаар гадуур хэрэглэх, булчинд тарих, дотуур хэрэглэхээр бэлтгэнэ.

/143./ Шилэн шүүлтүүрээр шүүхэд уусмалын эзэлхүүн нь хорогддоггүй сайн талтай. Ийм учраас алкалоид, будагч бодис, ферментийн уусмалыг шүүхэд хэрэглэж болохгүй.

/144./ Гадуур ба дотуур хэрэглэх шингэн эмийн хэлбэрийг жин, жин-эзэлхүүний аргаар бэлтгэж, эзэлхүүнээр олгоно. Яагаад гэвэл 5% ба түүнээс дээш эмийн бодис орсон цийдмэгийг аагтай цийдмэг гэнэ.

/145./ 5% ба түүнээс дээш эмийн бодис орсон хөвмөл, цийдмэгийг жингийн аргаар бэлтгэнэ. Хандмал, шингэн экстрактыг бэлэн усан ялгамал дээр нэмнэ.

/146./ Жигд ширхэгтэй нэгэн төрлийн нунтаг бэлтгэхийн тулд нэг шигшүүрээр шигшиж том хэсгүүдээс салгаад түүнийг дараагийн номерын шигшүүрээр шигшиж жижиг хэсгээс нь салгана. Яагаад гэвэл ганц шигшүүрээр шигшихэд жигд ширхэгтэй нунтаг болдоггүй.

/147./ Ариутгасан тарилгын нэрмэл усанд тавигддаг чухал шаардлагуудын нэг нь халууруулах бодис агуулаагүй байх явдал юм. Халууруулах бодис нь дэгдэмхий биш учир усны ууртай хамт нэрэгдэхгүй боловч усны дусалтай хамт хөргөгчид дамжин орж болох аюултай.

/148./ Температурыг 50-60°C-д хүргэхэд уураг бүлэгнэж ихэнх бичил биетний амьдрах чадвар алдагдаж 100°C-д ойртоход ихэнх эмгэг үүсгэгч бичил биетэн үхдэг. Яагаад гэвэл зарим вирус (халдварт шарын) ба үсэнцрүүд 100°C-д удаан хугацааны турш тэсвэртэй байх чадвартай байдаг

/149./ Тарилгын уусмалыг бэлтгэхэд хэрэглэгддэг эмийн бодисууд нь чанарын хувьд фармакопейн шаардлага хангасан химийн цэвэр ба шинжилгээнд зориулсан цэвэр зэрэглэлийн бодисууд байх ёстой. Яагаад гэвэл эмийн бодис нь заавал ямар нэг хольцыг өөртөө агуулсан байдаг.

/150./ Антибиотикууд нь исэлдэхэд биологийн идэвх нь сулрах буюу бүрмөсөн алдагдаж өөрчлөгдөнө. Яагаад гэвэл химийн өөрчлөлтийн дүнд тунадас үүсдэг.

/151./ Нунтгийн шахагдах чадвар гэдэг тодорхойлолтын хамгийн зөвийг сонгоно уу?

A. Нунтаг эмийн бодисын бат бэх бүтэцтэй систем үүсгэх чадварыг хэлнэ

B. Нунтаг бодисын нягтрах чадварыг хэлнэ.

C. Нунтаг эмийн бодисын бат бэх бүтэцтэй, холбоот дисперсийн систем үүсгэх чадварыг хэлнэ.

D. Нунтаг бодисын янз бүрийн нөхцөлд шахагдах чадварыг хэлнэ.

E. Нунтаг бодисын янз бүрийн бодистой хамт шахагдах чадварыг хэлнэ.

/152./ Нунтгийн асгарах жин гэдэг тодорхойлолтын хамгийн зөвийг сонгоно уу?

A. Чөлөөтэй асгарах нунтгийн нэгж эзэлхүүн дэх жинг хэлнэ.

B. Нунтаг бодисын хүндийн жинг хэлнэ.

C. Нунтаг бодисын хувийн жинг хэлнэ.

D. Чөлөөтэй асгарах нунтгийн жинг хэлнэ.

E. Нунтаг бодисын нягтыг хэлнэ.

/153./ Зарцуулалтын коэффициент гэж юу вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Материалын алдагдлыг эхлэл материалтай харьцуулсан харьцааг хэлнэ.

B. Эхлэл материалын нийт хэмжээг бэлэн гарсан бүтээгдэхүүний хэмжээнд харьцуулсан харьцааг хэлнэ

C. Бэлэн бүтээгдэхүүнийг эхлэл материалтай харьцуулсан харьцааг хэлнэ

D. Бэлэн бүтээгдэхүүнийг эхлэл материалтай харьцуулсан харьцааг процентаар илэрхийлсэн илэрхийллийг хэлнэ.

E. Эхлэл материал, эцсийн бүтээгдэхүүний нийлбэр юм.

/154./ Аэрозолийн баллон хэдий хэмжээний илүүдэл даралтыг даах чадвартай вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. 4-5 атм

B. 2-3 атм

C. 5-7 атм

D. 2-8 атм

E. 3-7 атм

/155./ Линимент гэж юу вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Тасалгааны температурт өөрийнхөө хэлбэрийг хадгалж чаддаг, биеийн температурт хайлдаг тосон эмийн хэлбэр юм.

B. Арьс салст бүрхэвчинд түрхэж хэрэглэдэг, унжралдсан өтгөвтөр консистенцтэй, гадуур хэрэглэдэг, нийлмэл тосон эмийн хэлбэр юм.

C. Харилцан уусдаггүй нарийн жижиглэгдсэн шингэнүүдээс тогтох бөгөөд гадаад байдлаараа нэгэн төрлийн, гадуур, дотуур болон тарилгаар хэрэглэгддэг тосон эмийн хэлбэр юм.

D. Арьс салст бүрхэвчинд түрхэж шингээн хэрэглэдэг, унжралдсан өтгөвтөр байдалтай дотуур хэрэглэдэг эмийн хэлбэр юм.

E. Арьс салст бүрхэвчинд шингээн түрхдэг, унжралдсан өтгөвтөр байдалтай, дотуур хэрэглэдэг, туналагдсан тосон эмийн хэлбэр юм.

/156./ Тарилгын зориулалттай нэрмэл усны чанарыг сайжруулах, пироген бодисгүй болгохын тулд технологийн ямар шийдлийг сонгох вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Усыг нэрэхдээ 1100-аас дээш температурт, тохиромжтой хурдтайгаар гадаргуугийн усны дусал үүсгэхгүй байхаар явуулна

B. Уснаас гадаргуугийн идэвхт бодис, менерал давс, хөөс үүсгэгч бодисуудыг урьдчилан зайлуулахгүйгээр тогтмол температурт, тохиромжтой хурдтайгаар гадаргуугийн усны дусал үүсгэхгүй байхаар нэрэлтийг явуулна.

C. Усыг нэрэхдээ менерал давс, хөөс үүсгэгч бодисуудыг урьдчилан зайлуулсны дараа тогтмол температурт, тохиромжтой хурдтайгаар задгай буцалгаж нэрнэ.

D. Уснаас гадаргуугийн идэвхт бодис, менерал давс, хөөс үүсгэгч бодисуудыг урьдчилан зайлуулсны дараа тогтмол температурт, тохиромжтой хурдтайгаар, гадаргуугийн усны дусал үүсгэхгүй байхаар нэрэлтийг явуулна

E. Уснаас гадаргуугийн идэвхт бодис, менерал давс, хөөс үүсгэгч бодисуудыг урьдчилан зайлуулсны дараа тогтмол температурт, тогтмол бус хурдтайгаар нэрэлтийг явуулна

/157./ Тарилгын зориулалттай уусгагчид тавих шаардлага ямар байх вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Уусгагч нь маш сайн уусгах чадвартай, хадгалах явцад тогтвор сайтай, физик-химийн хувьд эмийн бодистой харилцан үйлчлэлд ордоггүй, фармакологийн хувьд идэвхгүй, хэрэглэхэд тохиромжтой байхаас гадна үнэ хямдтай байвал тохиромжтой.

B. Уусгагч нь уусгах чадвар сайтай, хадгалах явцад тогтвор сайтай, физик- химийн хувьд эмийн бодистой харилцан үйлчлэлд ордоггүй, фармакологийн хувьд идэвхгүй, амархан хөлддөг, хэрэглэхэд тохиромжтой үнэ хямд байх шаардлагатай.

C. Уусгагч нь маш сайн уусгах чадвартай, хадгалах явцад тогтвор сайтай физик- химийн хувьд эмийн бодистой харилцан үйлчлэлд ордоггүй, фармакологийн хувьд идэвхгүй, хэрэглэхэд тохиромжтой өндөр үнэтэй байх шаардлагатай.

D. Уусгагч нь маш сайн уусгах чадвартай, хадгалах явцад тогтвор сайтай физик- химийн хувьд эмийн бодистой харилцан үйлчлэлд ордог, фармакологийн хувьд идэвхгүй, хэрэглэхэд тохиромжтой үнэ хямд байх хэрэгтэй.

E. Уусгагч нь маш сайн уусгах чадвартай, хадгалах явцад тогтвортой, физик- химийн хувьд эмийн бодистой харилцан үйлчлэлд ордоггүй, фармакологийн хувьд идэвхгүй, өндөр температурт хайлдаг, хэрэглэхэд тохиромжтой үнэ хямд байх хэрэгтэй.

/158./ Нүдний хальсан бэлдмэлийн зөв хариултыг сонгоно уу? Зөв хариултыг сонгоно уу?

A. Зууван хэлбэртэй, 9-6мм-ийн урт, 3.0-4.5мм өргөн, 0.35мм-ийн зузаантай 0.015гр дундаж жинтэй нулимасны шингэнтэй бионийцэлтэй ариутгагдсан эмийн хэлбэр юм.

B. Тэгш хэлбэртэй, 9-6мм-ийн урт, 3.0-4.5мм өргөн, 0.35мм-ийн зузаантай 0.015гр дундаж жинтэй нулимасны шингэнтэй бионицэлтэй нүдний эмийн хэлбэр юм.

C. Зууван хэлбэртэй, 6-9мм-ийн урт, 3.0-4.5мм өргөн, 0.35мм-ийн зузаантай 0.025гр дундаж жинтэй нулимасны шингэнтэй бионицэлтэй нүдний эмийн хэлбэр юм.

D. Зууван хэлбэртэй, 9-6мм-ийн урт, 2.0-2.5мм өргөн, 0.35мм-ийн зузаантай 0.015гр дундаж жинтэй нулимасны шигэнтэй бионицэлтэй нүдний эмийн хэлбэр юм.

Е. Зууван хэлбэртэй, тэгш өнцөгтэй 9-6мм-ийн урт, 3.0-4.5мм өргөн, 0.35мм-ийн зузаантай 0.015гр дундаж жинтэй нулимасны шигэнтэй бионицэлтэй нүдний эмийн хэлбэр юм.

/159./ Зөв хариулалтыг сонгоно уу?

А. АМБЕГ гэдэг нь хөдөлгөөнтэй ба хөдөлгөөнгүй 2 патроноос тогтсон пропан, кислородны холимогийн тусламжтайгаар дротыг хайлуулан туншилийг гарган авахад зориулсан тоног төхөөрөмж

В. АМБЕГ гэдэг нь хөдөлгөөнтэй 2 патроноос тогтсон пропан кислородны тусламжтайгаар гал гарган дөлөнд нь дротыг хайлуулан туншилийг гарган авахад зориулсан тоног төхөөрөмж

С. АМБЕГ гэдэг нь хөдөлгөөнгүй 2 патроноос тогтсон пропан кислородны тусламжтайгаар гал гарган дөлөнд нь дротыг хайлуулан туншилийг гарган авахад зориулсан тоног төхөөрөмж

Д. АМБЕГ гэдэг нь хөдөлгөөнтэй хөдөлгөөнгүй 2 патроноос тогтсон кислородны тусламжтайгаар гал гарган дөлөнд нь дротыг хайлуулан туншилийг гарган авахад зориулсан тоног төхөөрөмж

Е. АМБЕГ гэдэг нь хөдөлгөөнтэй хөдөлгөөнгүй 2 патроноос тогтсон дротыг хайлуулан шил гарган авахад зориулсан тоног төхөөрөмж

/160./ Мөхлөгжүүлэх процессын зөв тодорхойлолт аль нь вэ? Зөв хариултыг сонгоно уу?

А. Мөхлөгжүүлэх процесс гэдэг нь шахмал хийх массын урсах чанарыг сайжруулах, үелэхээс сэргийлэх зорилгоор нунтаг эмийн бодисыг тодорхой хэмжээний үр шиг болтол нь томруулах процессыг хэлнэ.

В. Мөхлөгжүүлэх процесс гэдэг нь шахмал хийх массын урсах чанарыг бууруулан үелэхээс сэргийлэх зорилгоор нунтаг эмийн бодисыг тодорхой хэмжээний үр шиг болтол нь жижиглэх процессыг хэлнэ

С. Мөхлөгжүүлэх процесс гэдэг нь шахмал хийх массын урсах чанарыг сайжруулах зорилгоор нунтаг эмийн бодисыг томруулах процессыг хэлнэ.

Д. Мөхлөгжүүлэх процесс гэж шахмалын масс хийх нунтаг эмийг үр шиг болтол нь томруулах процессыг хэлнэ.

Е. Мөхлөгжүүлэх процесс гэж шахмалын масс хийх массын урсах чанарыг сайжруулах зорилгоор эмийн бодисыг нунтаглах процессыг хэлнэ.

/161./ Зээрэнцэгт жигдрүүлэгч цагт хэдэн кг тосон түрхэц жигдрүүлдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

А. 100-150кг/цаг

В. 80-120кг/цаг

С. 50-60кг/цаг

Д. 60-90кг/цаг

Е. 60-80кг/цаг

/162./ Цувралын дугаар гэж юу вэ? Зөв хариултыг сонгоно уу?

А. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбогдсон бүх баримт бичгийн дугаар юм.

В. Дугаарлах хэсгийг тодорхойлж бичсэн зөв ажиллагааны заавар юм

С. Бүтээгдэхүүний хаяган дээрх цуврал, цувралын бүртгэл, шинжилгээний сертификат зэрэгт бичигдсэн тусгайлан танигддаг тоо буюу үсгээс тогтсон илэрхийлэл юм. Хэсэг бүтээгдэхүүнийг бусад бүтээгдэхүүнээс ялгах зорилгоор тусгайлан тавьсан хяналтын дугаар юм

Д. Үйлдвэрлэлийн бүх дамжлагыг дамжсан гэдгийг нотолсон дугаар

Е. Эцсийн савлалтаас гадна үйлдвэрлэлийн бүх дамжлагын бүтээглэхүүнийг хамарсан дугаар

/163./ Ариун бүтээгдэхүүн үйлдвэрлэх агаарын цэвэршилтийн В,С, Д зэрэглэлд хүрэхийн тулд агаарын солилцооны хэмнэл нь хэд байх ёстой вэ? Зөв хариултыг сонгоно уу?

А. 1 цагт 10-15

В. 1 цагт 20-с дээш

С. 1 цагт 15-с дээш

Д. 1 цагт 10 дээш

Е. 1 цагт 5-аас дээш

/164./ Дамжин бохирдох гэж юу вэ? Зөв хариултыг сонгоно уу?

А. Нэг бүтээгдэхүүний эхлэл материал, дамжлагын бүтээгдэхүүн эсвэл бэлэн бүтээгдэхүүн нь өөр бүтээгдэхүүний эхлэл материал болон үйлдвэрлэлийн явцын материалаар бохирдохыг хэлдэг

В. Үйлдвэрлэлийн явцад завсрын ба эцсийн бүтээгдэхүүн нь өөр бусад эхний материал ба эцсийн бүтээгдэхүүнээр бохирдохыг хэлнэ

С. Эцсийн савлалт, хаяглалтыг оруулан үйлдвэрлэлийн бүх шатны бохирдолтыг хэлнэ.

Д. Эмийн бүтээгдэхүүний чанарын өөрчлөлтийн шалтгаан нь болдог процесс юм

Е. эхний материал, эцсийн савлалт, хаяглалт зэрэг нь үйлдвэрлэлийн бүх бүтээгдэхүүнийг бохирдуулахыг хэлнэ

/165./ Хуурай халуун агаараар ариутгах процесс юунд үндэслэгддэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

А. Ариутгах камерт хуурай халуун агаар эргэлдэж байхад үндэслэгдэх ба гаднаас агаар орохоос сэргийлэхийн тулд нэмэлт даралтыг камерт барьж байх ёстой.

В. Ариутгах камераас агаарыг гадагшлуулахад үндэслэгддэг

С. Ариутгалд хэрэглэгдэж буй уур нь өндөр даралттай байх ёстой

Д. Ариутгах камерт халуун уур оруулахад үндэслэгддэг

Е. Ариутгах камерт халуун агаар оруулах хэрэгтэй

/166./ Хатуу биеийг жижиглэх процессын үр дүн нь юугаар илэрхийлэгдэх вэ? Зөв хариултыг сонгоно уу?

А. Жижиглэсэн материалын жижиглэлтийн ширхэгээр

В. Жижиглэсний дараах дундаж хэмжээгээр

С. Материалын жижиглэлтийн зэргээр

Д. Жижиглэхээс өмнөх дундаж хэмжээгээр

Е. Жижиглэлтийн үеийн дундаж хэмжээгээр

/167./ Хариулт буруу Дараах тодорхойлолтын аль нь хамгийн зөв бэ? Зөв хариултыг сонгоно уу?

А. Хоорондоо үл холилдох 2 шингэн фазаас тогтсон дисперсийн системийг хөвмөл гэнэ.

В. Шингэн орчин дотор хатуу жижиг хэсгүүд болох дисперсын фазаас тогтсон бичил нэгэн төрлийн бус дисперсын системийг хөвмөл гэнэ

С. Шингэн дотор хийн бөмбөлөг жигд тархсан дисперсын системийг хөвмөл гэнэ.

Д. Дотроо хатуу жижиг хэсгүүд агуулсан хийн холимогийг хөвмөл гэнэ.

Е. Шингэн дотор тархсан хий ба хатуу фазаудын холимогийг хөвмөл гэнэ.

/168./ Бүрхүүл үүсгэгч нь тодорхой хэмжээний бат бөх, уян хатан шинж чанартай байх ёстой. Учир нь бүрхүүлд савлагдсан эмийн чанар байдал, эмчилгээний үр дүн нь бүрхүүлийн шинж чанараас шууд хамаарна.

/169./ Хариулт буруу Эпидермаль гоюу нь хэсэг газрын үйлчилгээтэй. Учир нь эмийн бодис арьсны гадаргууд нэвчин эмчилгээний үйлдэл үзүүлнэ

/170./ Шулуун гэдэсний капсул эмийн хэлбэрийг биемахбод руу оруулахад эмийн бодис нь шулуун гэдэсний булчингийн ханын даралтын нөлөөгөөр хурдан чөлөөлөгдөн шимэгддэг. Тийм учраас эмчилгээний үйлдэл лааныхаас удаан илэрдэг гэж үздэг.

/171./ Аэрозоль эмийн хэлбэрийг тээвэрлэх, хадгалахад онцгой нөхцөл шаарддаг. Учир нь цохилтийн хүч, нарны туяаны шууд нөлөө, температурын огцом өсөлт зэрэг хүчин зүйлийн нөлөөгөөр эмийн бодисын үйлдэл буурдаг.

/172./ Хатуу желатинан капсулыг гарган авахдаа дуслын аргыг хэрэглэдэг. Учир нь тогтмол температуртай желатины уусмалд тэнхлэгээрээ эргэлдэх олон тооны металл хэвийг дүрээд авахдаа капсул хэлбэр үүсгэхэд үндэслэгддэг.

/173./ Эмийн бодисыг бие махбодид тодорхой хугацаагаар тогтмол концентрацтай байлгахын тулд матрикс шахмалыг хийдэг. Ийм шахмалыг гарган авахын тулд сараалж үүсгэгч бодисыг ашиглах ба тэдгээрийн дотор биологийн идэвхт бодисыг байрлуулж өгдөг.

/174./ Хариулт буруу Хатах процессын үр дүнд материалд агуулагдах чийг ууршдаг. Учир нь энэ үед агаарын парциаль даралт материалын дотоод даралт 2 тэнцдэг.

/175./ Шахмал хийх мөхлөгийг шахах үед таталцлын хүч бий болж хоорондоо хэлхэгдэн холбогдож гадаргууд нь нимгэн усан бүрхүүл үүсдэг. Учир нь энэ үед зөвхөн механик хүч үйлчилж байна гэж үздэг.

- /176./ Шахмал хийх массанд холбогч бодисыг их хэмжээгээр нэмж өгөх шаардлагатай. Учир нь холбогч бодисын тусламжтайгаар шахмал эмийн хэлбэрээс эмийн бодис хурдан чөлөөлөгдөж эмчилгээний үйлдлийг сайжруулдаг.
- /177./ Мөхлөг нь олон төрлийн фракцын бүрэлдэхүүнтэй байж болохгүй. Учир нь тэдгээр нь үелэн шахмалын дундаж жинд муугаар нөлөөлдөг.
- /178./ Бөмбөлөгт тээрмийн хурд маш их байвал төвөөс зугтах хүч бий болно. Ийм учраас жижиглэх үйл ажиллагаа маш сайн явагдана.
- /179./ Жижиглэх процессын дүнд хатуу биетийн гадаргуугийн талбай ихэсдэг. Тийм учраас бодисыг жижиглэх процессын онолын үндэс нь зөвхөн гадаргуугаар жижиглэгддэг гэж үздэг.
- /180./ Гетерогены тосон түрхэцийг бэлтгэх явцад 3 булт тээрмийг ашигладаг. Учир нь энэ тээрэм тосыг жигдрүүлж нэгэн төрлийн болгодог.
- /181./ Зарим тарилгын уусмалыг ариутгах үед температурын нөлөөгөөр хими-физикийн өөрчлөлтөнд ордог. Ийм учраас түүнийг тогтворжуулах зорилгоор антиоксидант бодис нэмдэг.
- /182./ Хуурай мөхлөгжүүлэх 2 арга байдаг үүний нэг нь эмийн бодисыг куба хэлбэртэй, ижил хэмжээтэй мөхлөг болтол нь шахаж нягтруулаад шахмал эмийн хэлбэрт оруулдаг арга юм. Учир нь энэ үед эмийн бодисын технологийн шинж чанар сайжирдаг
- /183./ Ходоод гэдэсний замд амархан задарч байх зорилгоор шахмалд хөвсийлгөгч бодисыг нэмдэг. Учир нь хөвсийлгөгч бодис нь шахмалын бат бөх чанарыг сайжруулдаг.
- /184./ Шахмал хийх мөхлөгийн чийглэг 2-3% байвал тохиромжтой гэж үздэг. Учир нь чийглэг хэт их бол урсах чанар нь мууддаг, хэт бага бол бат бөх чанар нь мууддаг.
- /185./ Сахарын сироп нь осмос даралтаар өндөр байдаг тул микро организмын усыг хатааж, амьдрах орчинг үгүй хийдэг. Ийм учраас 60%-иас бага концентрацтай сиропыг эм зүйн практикт байнга хэрэглэдэг.
- /186./ Хариулт буруу Материал чийгээ алдахдаа гүн капилярт байгаа гигроскопик чийгээ эхлэж алддаг. Учир нь эдгээр чийг нь сул холбоогоор холбогдсон механик агууламжтай чийг байдагтай холбоотой.
- /187./ Тоосруулан хатааж мөхлөгжүүлэх аргаар дулаанд тэсвэр муутай эмийн бодисыг мөхлөгжүүлэхэд хэрэглэнэ. Учир нь энэ үед эмийн бодис өндөр температурын нөлөөнд автагддаггүй давуу талтай.
- /188./ Хэрэв шахмал хийх масс нь норгоход мөхлөг болж чадахаар байвал холбогч бодисоор нэрмэл усыг хэрэглэдэг. Учир нь эмийн бодисыг усаар норгож нойтон масс үүсгээд нойтон мөхлөгжүүлэхэд боломжийн мөхлөг үүсдэг.
- /189./ Тарилгын зориулалтаар хэрэглэх фермент ба дааврын гаралтай бэлдмэлийг мембранан шүүлтүүрээр шүүх аргаар ариутгана. Учир нь ихэнх фермент, даавар нь тогтвор муутай
- /190./ Биотехнологийн аргаар ургамлын эд эсийн өсгөвөрөөс эмийн бэлдмэл гарган авахдаа өсгөвөрт халдваргүйжүүлэх бодис, бактери устгах дэн хэрэглэж болохгүй. Учир нь эдгээрийн нөлөөгөөр эсийн өсөлт идэвхгүй болно.
- /191./ Ямар ч түүхий эдийг хандлахын өмнө заавал дэвтээх шаардлагатай. Учир нь дэвтээхэд түүхий эд хөөж, хандлагч шингэн орох боломж сайжирна.
- /192./ Хандлагч шингэн өтгөн консистенцитэй байх нь хандлалтанд сайнаар нөлөөлнө. Учир нь өтгөн консистенцитэй хандлагч шингэн түүхий эдэд нэвчин орохдоо сайн байдаг.
- /193./ Нэрмэл усыг хандлагч болгон халаалт хэрэглэж хандлахад диффузийн процесс хурдасна. Учир нь халуун усанд цардуул хөвмөл үүсгэнэ.
- /194./ Түүхий эдийг хэт жижиглэх нь хандлалтанд сайнаар нөлөөлнө. Учир нь хэт жижиглэхэд хандлагч шингэний түүхий эдэд нэвчин орох чадвар нэмэгдэнэ.
- /195./ Хандлалтын үед концентрацийн ялгааг ихэсгэхийн тулд хандлагчийг үе үе солино. Учир нь концентрацийн ялгаа их байх нь хандлах процессыг нэмэгдүүлнэ.
- /196./ Дэвтээсэн түүхий эдийг перколяторт хийхдээ чигжилтийг тохируулах нь чухал. Учир нь чигжилт сийрэг байвал экстрагент түүхий эдэд нэвтрэн ороход сайнаар нөлөөлнө.
- /197./

Шингэн хандыг хадгалах явцад температур буурснаар тунадасжих үзэгдэл тохиолдож болно. Учир нь шингэн ханданд хандлагдах бодис 25% хүртэл агуулагдана.

/198./ Ургамлын түүхий эдийг хандлахын өмнө жижиглэх шаардлагатай. Учир нь гадаргуугийн талбай ихэссэнээр хандлагчтай хүрэлцэх талбай нэмэгдэнэ.

/199./ Хандлах процессыг эрчимжүүлэхийн тулд гадаргуугийн идэвхт бодис нэмж болно. Учир нь гадаргуугийн идэвхт бодис фазуудын гадаргуугийн таталцлын хүчийг нэмэгдүүлнэ

/200./ Цахилгаан гүйдлийн нөлөөгөөр дотоодын диффузын коэффициент ихэснэ. Учир нь биологийн идэвхт бодисын молекулын ионы хөдөлгөөн хурдасна.

/201./ Бичил биетний өсгөвөрөөс гарган авсан ферментийг эмнэлгийн практикт өргөн хэрэглэнэ. Учир нь эдгээр нь олдоц сайтай, үйлдвэрлэл нь эдийн засгийн хувьд ашигтай.

/202./ Шүүсийг цэвэрлэхийн тулд хурдан халааж хөргөнө. Учир нь энэ үед пектин, уургийн бодис, салс тунадасжина.

/203./ Этилийн спиртийн эзэлхүүний процентыг 200С-д хэмжинэ. Учир нь спиртийн эзэлхүүн температураас хамааран өөрчлөгддөг.

/204./ Хариулт буруу Мацерацийн аргыг хуйлруулж хандлах замаар эрчимжүүлж болно. Учир нь кавитацийн үзэгдэл хандлалтыг түргэсгэнэ.

/205./ Тарваган шийрийн шахмалын нунтгаас 4.0055 гр-г хэмжин авч алкалоидыг нь хлорформоор хандлан ялган авч хлорформыг нь ууршуулан үлдэгдлийг нь 5мл спирт 15 мл усанд уусгаад метил улаан- метил хөхийн / 2:1/ индикатортой 0.01N давсны хүчлээр титрлэхэд 0.53 мл орсон ба шахмалын дундаж жин нь 0.30329 бол нийлбэр алкалоидыг граммаар ол /T=0.00244/

A. 0.000095

B. 0.000090

C. 0.000098

D. 0.00011

E. 0.00013

/206./ Барбитуратуудыг хоорондоос нь ялган таних урвалжуудыг заана уу?

A. Кобальтийн нитрат

B. Мөнгөний нитрат

C. Зэсийн сульфат

D. FeCl₃

E. Давсны хүчил

/207./ Барбитуратуудын натрийн давсуудын усанд уусах шинж чанар нь буурдаг нь юутай холбоотой вэ?

A. Исэлдэхтэй

B. Ангижрахтай

C. Полимержих

D. Нэгдэх урвалтай

E. Гидролизтай

/208./ Натрийн бромид 2гр, Новокайны гидрохлорид 1 гр бүхий 100 мл уусмалаас 1 мл-г авч 500мл-н хэмжээт колбонд хийж хэмжээс хүртэл нэрмэл усаар шингэлэв. Түүнээс 10 мл-г авч 25мл хүртэл нэрмэл усаар сулруулаад 288 нм-т спектрофотометрдэхэд D=0.650 байв. / E=639.9 / Новокайны гидрохлоридын хэмжээг гр-р ол?

A. 2.26

B. 1.26

C. 1.11

D. 1.23

E. 1.18

/209./ Натрийн бромид 2гр, новокайны гидрохлорид 1гр бүхий 100 мл уусмалаас 5мл-г авч 2-3 мл калийн хроматын индикатор дусааж 0.1нормалийн мөнгөний нитратаар улбар шар өнгө үүстэл титрлэхэд 10.4мл зарцуулагдав. Уусмалд агуулагдах натрийн бромидын хэмжээг процентоор тодорхойл? /T=0.01029/

A. 1%

B. 1.5 %

C. 2.14%

D. 2.3%

E. 2.35%

/210./ Барбитуратуудын натрийн давсанд тооны тодорхойлолтоор хийхэд аль аргыг ашиглах вэ?

A. Усан биш орчинд алкалиметри

B. Усан орчинд алкалиметри

C. Усан, спиртын орчинд ацидиметри

D. Усан орчинд ацидиметри

E. Алкали болон ацидиметри

/211./ Эуфиллины усанд уусах чанар нь дараах ямар нөхцлөөс өөрчлөгддөг вэ?

A. Агаарын нүүрсхүчлээс

B. Гэрлээс

C. Агаарын хүчилтөрөгчөөс

D. Агаарын азотоос

E. Агаарын хүхрээс

/212./ Бензоат ба салицилат хамт байгаа үед ямар урвалжаар таних вэ?

A. NaNO_2

B. CuSO_4

C. CaCl_2

D. $\text{Co}[\text{NO}_3]_2$

E. FeCl_3

/213./ Глюкоз, аскорбины хүчилтэй нэгэн жоронд байгаа үед ялган таних урвал юун дээр үндэслэгдсэн бэ?

A. Хүчиллэг шүлтлэгийн чанарт

B. Исэлдэн ангижрах шинж чанарын ялгаан дээр

C. Гидролизод орж задардаг ялгаа

D. Усанд уусах ялгаа

E. Органик уусгагчид уусах ялгаа

/214./ Барбитуратуудын натрийн давсуудын усанд уусах шинж чанар нь буурдаг нь юутай холбоотой вэ?

A. Исэлдэхтэй

B. Ангижрахтай

C. Полимержих

D. Нэгдэх урвалтай

E. Гидролизтай

/215./ Барбитуратуудын натрийн давсанд тооны тодорхойлолтоор хийхэд аль аргыг ашиглах вэ?

A. Усан биш орчинд алкалиметри

B. Усан орчинд алкалиметри

C. Усан, спиртын орчинд ацидиметри

D. Усан орчинд ацидиметри

E. Алкали болон ацидиметри

/216./ Эуфиллины усанд уусах чанар нь дараах ямар нөхцлөөс өөрчлөгддөг вэ?

A. Агаарын нүүрсхүчлээс

B. Гэрлээс

C. Агаарын хүчилтөрөгчөөс

D. Агаарын азотоос

E. Агаарын хүхрээс

/217./ Глюкоз, аскорбины хүчилтэй нэгэн жоронд байгаа үед ялган таних урвал юун дээр үндэслэгдсэн бэ?

A. Хүчиллэг шүлтлэгийн чанарт

B. Исэлдэн ангижрах шинж чанарын ялгаан дээр

C. Гидролизод орж задардаг ялгаа

D. Усанд уусах ялгаа

Е. Органик уусгагчид уусах ялгаа

/218./ Тропаны бүлгийн алкалоидын чанарын шинжилгээнд Витали-Морены сорилыг хэрэглэдэг. Энэ нь алкалоидыг гидролизд оруулсны дараа нитрожуулж, хиноид бүтэц үүсэх шинж чанарт үндэслэнэ.

/219./ Аскорбины хүчлийн уусмалыг тогтворжуулахын тулд натрийн метабисульфит эсвэл натрийн сульфит нэмж өгдөг. Учир нь аскорбины хүчил нь агаар, металл, хүчил, шүлтийн нөлөөгөөр амархан исэлддэг.

/220./ +50С-д формальдегидыг хадгалахад цагаан тунадас бууна. Учир нь формальдегид исэлдэх урвалд орно.

/221./ Фенолт нэгдлүүдийн төмрийн хлоридтой урвалд ороход илрэх өнгө өөр өөр байдаг. Учир нь энэ нь тухайн нэгдлийн найрлаганд орох бусад функциональ бүлгүүдээс хамаарна.

/222./ Бензойны хүчлийг эмнэлгийн практикт натрийн давс байдлаар хэрэглэдэг. Учир нь натрийн давс байдлаар хэрэглэхэд бензойны хүчлийн цочроох үйлдэл багасдаг.

/223./ Хинолины уламжлалын алкалоидын чанарын шинжилгээнд Витали-Морены сорилыг хэрэглэдэг. Энэ нь алкалоидыг гидролизд оруулсны дараа исэлдүүлж, ацетоны орчинд калийн гидроксидоор үйлчилж, саванжих шинж чанарт үндэслэнэ.

/224./ Эмийн шинжилгээнд барбитуратуудаас 0,05 г. орчмыг авч 2 мл 95 % -ийн этанолд уусгаад дээр нь 1 дусал кальцийн хлорид, 2 дусал кобальтын нитрат, 3 дусал натрийн гидроксидын уусмал нэмэхэд хөх ягаан өнгөтэй болдог. Энэ нь барбитуратууд дээрхи орчинд кобальтын нитраттай өнгөтэй комплекс нэгдэл үүсгэдэгтэй холбоотой юм.

/225./ Фармакопейн дагуу нэрмэл ус ангижруулагч хольцгүй байх ёстой. Дараах урвалуудын алинаар нь ангижруулагч хольцгүйг тодорхойлох вэ?

А. дифениламины уусмалд хөх өнгө өгөх

В. хүхрийн хүчлийн орчинд калийн перманганатын өнгийг хувиргахгүй байх

С. хүхрийн хүчлийн орчинд калийн перманганатын өнгийг арилгах буюу хувиргах

Д. давсны хүчлийн орчинд калийн перманганатын өнгийг хувиргахгүй байх

Е. давсны хүчлийн орчинд калийн перманганатын өнгийг арилгах буюу хувиргах

/226./ Карбоны хүчлийн эмийн бэлдмэлийн уусмалыг H_2SO_4 –ээр хүчиллэгжүүлж $KMnO_4$ нэмж халаахад ацетальдегидийн үнэр үнэртэв. Ямар анион бэ?

А. ацетат

В. цитрат

С. карбонат

Д. лактат

Е. глюконат

/227./ Шүүлтийн цаасан дээр $FeCl_3$ дусааж, дээр нь эмийн хэлбэрээс 1 дусаахад хөх ягаан хүрээтэй боровтор шар толбо үүсэв. Эмийн хэлбэрт ямар ион агуулагдаж байна вэ?

А. ацетат

В. ацетат, бензоат

С. салицилат, бензоат

Д. салицилат, ацетат

Е. бензоат

/228./ Барбитурын хүчлийн уламжлалын бүтцийн үндэс нь ямар гетероцагираг вэ?

А. Барбитурын хүчлийн давс

В. Урацилын уламжлал

С. Пиримидин

Д. Ангит цагирагт

Е. 6 гишүүнт ангит цагирагт
/229./ Өгөгдсөн химийн нэр ямар эмнийх вэ?
1,2 дифенил-4-бутил пиразолидиндион-3,5

А. Антипирин

В. Амидопирин

С. Бутадион

Д. анальгин

Е. Пиразолын уламжлалын бэлдмэл

/230./ Эмийн хэлбэр дэх амидопириний тооны тодорхойлолт хийхэд ямар индикатор ашигладаг вэ?

А. Метилийн улаан, метилийн хөх (1:1)

В. Метилийн улбар шар, метилийн хөх (1:1)

С. метилийн улбар шар

Д. тропеолин оо- метилийн хөх (1:1)

Е. Метилийн хөх

/231./ Пиразолон-5 эмийн уусмалруу 1 дусал $FeCl_3$ нэмэхэд тод улаан өнгө үүсэв. Энэ нь ямар эм байсан бэ?

А. Амидопирин

В. Анальгин

С. Антипирин

Д. бутадион

Е. Аналпирин

/232./ Эмийн бэлдмэлийг усанд уусган, 1 мл мөнгөний нитратын аммиакийн уусмал нэмэхэд шаравтар өнгийн тунадас үүсч, халаахад бараан өнгөнд шилжин, хуруун шилний хананд” мөнгөн толь” үүсэв. Энэ ямар бэлдмэл байсан бэ?

А. Амидопирин

В. Антипирин

С. Изониазид

Д. кордиамин

Е. Никотинамид

/233./ Тодорхойлж буй бодисын –метокси бүлгийг бромын усаар исэлдүүлж аммиак нэмэхэд ногоон өнгөтэй о-хиноид бүтэц бүхий нэгдэл үүсэв. Энэ сорилын нэрийг сонгоно уу?

А. Мурексид

В. Нингидрин

С. Таллейохин

Д. Витали-Морены

Е. Марки

/234./ Дараах бодисуудын аль нь гликозид бүтэцтэй вэ?

А. Токоферол

В. Хлорамфеникол

С. Неодикумарин

Д. строфантин

Е. Стрептомицины сульфат

/235./ Алкалоидын ерөнхий тунадасжуулах урвалжид хамаарагдах урвалжийг заана уу?

А. Витали-Морены урвалж

В. Мурексидын сорил

С. Пикриний хүчил, Драгендорфийн урвалж, Вагнерийн урвалж

Д. Танин, Несслерийн урвалж, Бушардын урвалж

Е. Таллейохинины сорил

/236./ Алкалоидын уусмал дээр 2-3 дусал бромын ус, 1 мл аммонийн гидроксид нэмэхэд ногоон өнгө үүсэв. Энэ ямар бүлгийн алкалоид вэ?

А. Опиин бүлгийн

В. Изохинолины бүлгийн

- C. Хиолины бүлгийн
D. бензилизохиолины бүлгийн
E. Фенантренизохиолины бүлгийн
- /237./ Фармакопейн заалтын дагуу кодеиныг морфиноос ямар урвалаар ялгах вэ
A. Маркийн урвалжтай хөх ягаан өнгө үүсгэнэ
B. Маркийн урвалжтай улаан ягаан өнгө үүсч удалгүй хөх ягаанд шилжинэ
- C. конц. азотын хүчилтэй улаан шар өнгө үүсгэнэ
D. Төмрийн хлоридтой хөх ягаан өнгө үүсгэнэ
E. концентрацитай давсны хүчилтэй улаан өнгө үүсгэнэ
- /238./ Шинжилгээнд тосонд уусдаг. цайвар шар өнгийн, зуурамтгай, тосорхог шингэн (витаминий төрлийн) иржээ. Гэрэлд исэлдэж өнгө нь харладаг. Гэрлийн хугарлын илтгэгч нь 1,4960-1,4985. Энэ ямар витамин бэ?
A. ретинолын ацетат
B. эргокальциферол
C. токоферолын ацетат
D. холекальциферол
E. викасол
- /239./ Дор өгөгдсөн химийн нэр ямар антибиотикийнх болохыг заах. 4-диметиламино-1, 4, 4а, 5, 5а, 6, 11, 12а-октагидро- 3, 6, 10, 12, 12а пентаокси-6-метил-1, 11-дикетонафтацен-2 карбоксиамидын гидрохлорид
A. хлорамфеникол
B. тетрациклины гидрохлорид
C. окситетрациклины гидрохлорид
D. хлортетрациклин
E. хлормицетин
- /240./ Пиразолон-5 уламжлалын эмийн уусмал руу мөнгөний нитрат нэмэхэд эхлээд хөх ягаан өнгө үүсч, дараа нь саарал өнгийн тунадас буусан бол энэ нь ямар эм байсан бэ?
A. анальгин
B. антипирин
C. Амидопирин
D. Бутадион
E. Фенилбутазон
- /241./ Аскорбины хүчлийн тарилгын уусмалыг тогтворжуулахад ямар бодисыг хэрэглэх вэ?
A. натрийн гидрокарбонат ба натрийн хлорид
B. натрийн хлорид ба натрийн метабисульфит
C. Натрийн гидроксид ба натрийн метабисульфат
D. натрийн хлорид
E. Натрийн гидрокарбонат ба натрийн метабисульфит
- /242./ Камфор, преднизолон, прегниний бүтэц дэх ерөнхий бүлгийг нэрлэнэ үү.
A. кето
B. гидроксиль
C. Альфа-кетальный
D. циклопентанпергидрофенантрены цөм
E. Сөөлжилсөн 2-чийн холбоо
- /243./ 1 мл шинжилж буй уусмал дээр хуурай натрийн ацетат болон 2мл хүхрийн хүчил хийж халаахад этилацетатын үнэр гарсан бол уг шинжилгээгээр ямар бодис илэрсэн бэ?
A. Фенол
B. Бензойны хүчил
C. Этилийн спирт
D. Метилийн спирт
E. Цууны хүчил
- /244./ Шүлтлэг уусмалаас авсан хлороформын ханданд ямар бодисуудыг тодорхойлох вэ?
1. Барбитурат

2. Изохинолины уламжлалын алкалоид
3. Салицилын хүчил
4. Тропаны уламжлалын алкалоид
5. Пурины уламжлалын алкалоид

/245./ Шинжилж буй уусмал дээр фенолфталеины спиртийн уусмал нэмэхэд ягаан өнгөтэй болох ба үүн дээр барийн хлорид нэмэхэд шинжилж буй материалд идэмхий шүлт байвал фенолфталеины ягаан өнгө

1. Арилна
2. Хөх өнгөнд шилжинэ
3. Улаан өнгөнд шилжинэ
4. Хэвээр хадгалагдана
5. Улбар шар өнгөнд шилжинэ

/246./ Хортой, хүчтэй үйлчлэгч бодисуудыг усны ууртай нэрэхэд эхлээд биоматериалыг хүчиллэгжүүлдэг. Ямар хүчлийг хэрэглэдэг вэ?

1. Чулуун дарсны хүчил
2. Хүхрийн хүчил
3. Хурган чихний хүчил
4. Цууны хүчил
5. Давсны хүчил

/247./ Минерализатын шүүгдсэнд ямар металл хорыг илрүүлэх вэ?

1. Мөнгө
2. Хром
3. Магни
4. Цайр
5. Кадми

/248./ Биоматериалд хүчиллэг орчин дараах бодисын нөлөөнөөс болж үүснэ. Үүнд:

1. Хүчтэй хүчлүүдийн хүчиллэг давс
2. Чөлөөт хүчлүүд
3. Хүнд металлын давсууд
4. Карбонатууд
5. Силикатууд

/249./ Хүнд металлын давсын хордлогын үед хэрэглэх антидотыг заана уу?

1. Витамин В6 5% уусмал
2. Натрийн тиосульфатын 30% уусмал
3. Протамины сульфатын 1% уусмал
4. Унитол 5% уусмал
5. Танины уусмал

/250./ Хлоральгидратаар хордсон үед ямар шинж тэмдэг илрэх вэ?

1. Эхлээд ТМС-ийг сэргээнэ.
2. Зүрх судасны системд хүчтэй нөлөөлнө.
3. Паралич үүсгэнэ.
4. Өтгөн хатна.
5. Ханиалгана.

/251./ 1 мл шинжилж буй уусмал дээр 1 мл 1% шинэхэн бэлтгэсэн резорцины шүлтлэг уусмал нэмж халаахад ягаан өнгө үүссэн бол уг дээжинд ямар хорт бодис агуулагдаж байна вэ?

1. Хлороформ
2. Хлоралгидрат
3. 4 хлорт нүүрстөрөгч
4. Формальдегид
5. Синилийн хүчил

/252./ Хүчиллэг уусмалаас хандлагдах бодисуудыг заана уу.

1. Кофейн
2. Барбитал
3. Стрихнин

4. Фенобарбитал

5. Атропин

/253./ Морфины хордлогын үед илрэх шинж тэмдэгийг заана уу.

1. Толгой эргэх

2. Ухаан балартах

3. Нойрмоглох

4. Коллапсид орох

5. Хөөрлийн байдалд орох

/254./ Атропины тунг хэтрүүлэн хэрэглэсний улмаас бие махбодид үүсэх шинж тэмдэгийг нэрлэнэ үү.

1. Хий юм харах

2. Хөдөлгөөн ихсэх

3. Чанга ярих

4. Хамар, ам хатах

5. Хүүхэн хараа нарийсах

/255./ Метилийн спиртийн хоруу чанарыг заана уу?

1. Мэдрэлийн системийг гэмтээнэ.

2. Нүдний эвэрлэг бүрхүүл ба харааны мэдрэлийг гэмтээнэ.

3. Зүрх судасны системийг гэмтээнэ.

4. Нүд сохлоно

5. Этанолын исэлдэлтийг 50% хүртэл бууруулна.

/256./ Никотины хүчлийн хордлогын үед ямар шинж тэмдэг илрэх вэ?

1. ТМС дарангуйлагдана

2. Толгой эргэх

3. Бөөлжих, гүйлгэх

4. Амьсгалын төв дарангуйлагдана

5. Хүүхэн хараа нарийсах

/257./ Хар тугалгаар хордсон үед ямар эд эрхтнийг гэмтээдэг вэ?

1. Хараанд өөрчлөлт орно

2. Цус, судсанд өөрчлөлт орно.

3. Шүдийг гэмтээнэ.

4. Мэдрэлийн эдэд өөрчлөлт орно.

5. Үс хугарамтгай болно.

/258./ Мөнгөн усны хордлогын үед илрэх шинж тэмдэгийг заана уу.

1. Аманд металл амтагдана.

2. Ходоод халуун оргино.

3. Бөөлжинө.

4. Арьсан дээр тууралт гарна.

5. Арьсан дээр хөх толбо илрэнэ.

/259./ Манганийн нэгдлийн бие махбодид үзүүлэх хорт нөлөөллийг заана уу?

1. ТМС-д нөлөөлнө.

2. Бөөр гэмтээнэ.

3. Уушиг гэмтээнэ.

4. Элэг гэмтээнэ.

5. Ходоод гэдэсний ханыг түлнэ.

/260./ Гемодиализын аргыг ямар тохиолдолд хэрэглэхэд тохиромжтой вэ?

1. Хорт бодисууд цусны уурагтай бат бөх холбоо үүсгэдэг үед

2. Био шингэнд түргэн уусдаг бодисын хордлогын үед

3. Өөх тосны төрлийн бодистой бат бөх холбоо үүсгэсэн үед

4. Молекул жин багатай бодисын хордлогын үед

5. Хордлогын хожуу үед ч хэрэглэхэд тохиромжтой

/261./ Ургамлын хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт ямар үйл ажиллагаа явуулахыг хориглодог вэ?

1. хорио цээртэй нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх

2. Ургамлын гаралтай бүтээгдхүүнийг зөвшөөрөлгүй тээвэрлэх

3. хөнөөлийн голомтот байрыг зөвшөөрөл авалгүй ашиглах

4. ургамлын түүхий эдийг оруулах, дамжин өнгөрүүлэх

5. халдвартай үр суулгацыг тариалах

/262./ Алкалоид нь суурилаг шинж чанартай. Учир нь гидроксильн бүлэг агуулсан байна.

/263./ Каротин нь усанд уусдаг витаминд хамаарагдана. Учир нь каротин чацарганы үр жимсэнд агуулагддаг.

/264./ Ургамлын түүхий эдэд флавоноид илрүүлэх энгийн арга нь Цианидиний сорил юм. Тийм учраас хроматографын аргуудаас өмнө энэ таних урвалыг ихэвчлэн явуулдаг

/265./ ЭУТЭ-ээс полисахаруудыг ямар уусгагчаар ялгаж авдаг вэ?

A. 95%-ийн спиртээр

B. Усаар

C. Эфирээр

D. Хлороформоор

E. Петролейний эфирээр

/266./ Таван салаа ба ажигийн түүхий эд дэх биологийн идэвхит бодисыг ФК-д зааснаар ямар аргаар тодорхойлдог вэ?

A. Спектрофотометр

B. Жингийн аргаар

C. Фотоэлектрокалориметрээр

D. Саармагжуулах аргаар

E. Хий-шингэний хроматографын аргаар

/267./ Ямар биологийн идэвхит бодис агуулсан түүхий эдэд биологийн стандартчилал явуулдаг вэ?

A. Алкалоид

B. Эфирийн тос

C. Зүрхний гликозид

D. Антроцений уламжлалууд

E. Экдизонууд

/268./ Сапонин нь дараахь түүхий эдийн үндсэн үйлчлэгч бодис

A. Строфантын үр жимс

B. Чихэр өвсний үндэс

C. Алтан хундагын өвс

D. Бамбайн үндэс ба үндэслэг иш

E. Алтан гагнуурын үндэс ба үндэслэг иш

/269./ Дараахь түүхий эдүүдийн аль нь алкалоид агуулдаг вэ.

A. Марцны хоржигнуур

B. Алтанцэгцүүхэй

C. Гурван цэцэгт нил

D. Ээрэм шарилж

E. Алтан товч

/270./ ЭУТЭ-ийн чанарын тодорхойлолтод юу хамаарах вэ?

A. Тоон үзүүлэлтүүд

B. Хадгалах хугацаа

C. ЭУТЭ-ийг бэлтгэх хугацаа

D. Фармакологийн үндсэн үйлдэл

E. Түүхий эдийн чанарын сорилтууд

/271./ Ферментүүдийн ангилалыг зөв нэрлэнэ үү.

1. Ялгаруулагч ферментүүд

2. Оксиредуктазууд буюу исэлдэн ангижрах урвалыг хурдасгах ферментүүд

3.

Эд эсийн нөхөн төлжилтийг дэмжих үйлдэлтэй ферментүүд

4. Гидролазууд буюу задралд оруулагч ферментүүд

5. Коферментүүд

/272./ Үндсэн молекулын исэлдэж байгаа бүлгээс нь хамааран оксидаза ферментүүдийг хэрхэн ангилдаг вэ.

1. Уусгагчийн

2. Кетоны

3. Хүчлийн

4. Альдегидийн

5. Спиртийн

/273./ Ургамлын хоёрдогч нийлэгжлийн бүтээгдхүүнд ямар бодисууд хамаарагдах вэ.

1. Эфирийн тос

2. Аргаах бодис

3. Алкалоид

4. Флавоноид

5. Антроцен

/274./ Флавоноидыг ургамлын түүхий эдэд нимгэн үеийн хроматографын аргаар илрүүлэхдээ хроматограммыг ямар уусмалаар шүршиж илрүүлдэг вэ?

1. Фосфор молибдений хүчил

2. Хөнгөн цагааны хлорид

3. Драгендорф

4. Төмрийн хлорид

5. Пикриний хүчил

/275./ Шувуун тарнаас ямар биологийн идэвхт бодисийг цэвэршүүлэн ялган авдаг вэ?

1. Мочевин

2. Кверцетин

3. Рутин

4. Авикулярин

5. Апигенин

/276./ Алкалоид нь 2-гч нийлэгжлийн бүтээгдхүүн. Ийм учраас бага молекулт нэгдэлд хамаарагддаг.

/277./ Өөх тос хүчлийн орчинд гидролизод орох процессыг саванжих гэнэ. Учир нь глицерин нь өөхний хүчил болон задарна.

/278./ Эмийн ургамлын түүхий эдийг 10-12%-ийн чийглэгтэй болтол нь хатааж хэрэглэдэг. Яагаад гэвэл эд эсэд орших биологийн идэвхт бодис нь чанараа алдаагүй байдаг.

/279./ Витамин агуулсан түүхий эдийг усанд ба тосонд уусдаг гэж 2 ангилна. Учир нь химийн бүтцээр нь ангилдаггүй.

/280./ Эфирийн тос усны ууртай хамт нэрэгдэх чанартай. Ийм учраас ФК-н 1-р аргаар буюу усны ууртай хамт нэрэх аргаар түүхий эдээс ялган авдаг.

/281./ Ургамлын түүхий эдэд флавоноид илрүүлэх энгийн арга нь Цианидиний сорил юм. Тийм учраас хроматографын аргуудаас өмнө энэ таних урвалыг ихэвчлэн явуулдаг.

/282./ Уламжлалт монгол анагаах ухааны онол дахь өвчнийг эмчлэх ерөндөгийг зөв сонгоно уу.

1. Эм

2. Засал

3. Идээ

4. Ундаа

5. Явдал мөр

/283./ Одон зурхайн таван махбодын сургааль ерөнхийдөө юуны харилцаа холбоог тодорхойлдог вэ зөв хариултыг сонгоно уу.

1. одон орныг

2. хүний бие бүтэц

3. хүний биед гарах өөрчлөлтүүд

4. хүн байгаль хоёр

5. шим ертөнцийн элдэв үзэгдэл

/284./ 4- улиралын хувиралтын нөлөөнд үүсдэг 5- цулын хоорондын харьцааг хэрхэн шинжлэх вэ? Зөв хариултыг сонгоно уу.

1. Эх
2. Нөхөр
3. Дайсан
4. хөвгүүн
5. судлын лугшилтаар

/285./ Бадган махбодын орших орныг зөв сонгоно уу.

1. Зүрх өрцнөөс дээш
2. Бөөр
3. Уушиг
4. Давсаг
5. Өөхөнд

/286./ Бие хэл сэтгэлийн хөдөлгөөнийг тогтуун болгох, шингээлтэнд хавсрах, тамирыг шимжүүлэх, нойрсуулах, урт наслуулах, тэсвэртэй болгох, үесийг барилдуулах үйлдэлтэй ямар бадганы үйл ажиллагаа вэ?

1. Шүтүүлэгч бадгана
2. Ялзлагч бадгана
3. Хангагч бадгана
4. Ерөнхий бадгана
5. Барилдуулагч бадгана

/287./ Гар, хөл, үе мөч хөших, хөл гарыг жийж хумихад өвдөх, хүчлэхэд хатууран хавдах зэргийг дарж чадах эмийг ямар эрдэмтэй эм гэх вэ?

1. Зөөлөн эрдэмтэй эм
2. Хүндийн эрдэмтэй эм
3. Бүлээний эрдэмтэй эм
4. Тослог эрдэмтэй эм
5. Батлаг эрдэмтэй эм

/288./ Эмт бодисоо эмт сүмс, архи, сүү, шар тос, ус мэтийн шингэн биетэд хийж буцалгахыг

- A. Жигнэх
- B. Хуйхлах
- C. Чанах
- D. Хайлуулах
- E. Шаргаах

/289./ Монгол эмийн ерийн мэдлэг номонд гишүүний тухай юу гэж бичсэн байдаг вэ.

- A. Гишүүнийг архинд чанаж
- B. Гишүүнийг шатааж
- C. Гишүүнийг хярвастал хуурч
- D. Гишүүнийг архинд хуурч
- E. Гишүүний сахал үндсийг шатааж

/290./ Гишүүнийг номхотголгүйгээр хэрэглэвэл ямар үйлдэл үзүүлэх вэ.

- A. Хурж бөөгнөрснийг тараана
- B. Урвуу арилгагч хийн гүйдлийг сайжруулна.
- C. Хүний цусны тунгалагийн эсрэг цогцын урвалыг таслана
- D. Бактерийг устгана.
- E. Ходоодыг хялбар гэмтээнэ.

/291./ Уламжлалт монгол эмийн номхотголын онолыг орчин үеийн шинжлэх ухааны онолоор баяжуулж монгол эмийн номхотгох арга болон мэргэжлийг дээшлүүлж эмт бодисын чанарыг нэмэгдүүлж эмчилгээн дээрх үйлдлийг нь нэн сайн бадруулах болно. Зөв хариултыг сонгоно уу.

1. Шатаах зорилго
2. Судлах арга
3. Номхотгох зорилго
4. Судлах зорилго
5. Дэвтээх зорилго

/292./ Нурамлах аргын зорилго. Зөв хариултыг сонгоно уу.

1. Эмт бодисын дэгтэмтгий чанарыг арилгах
2. Эмт бодисыг цэвэршүүлэх
3. Эмт бодисын муухай үнэр амтыг арилгана.
4. Эмт бодисын хорыг багасгана.
5. Эмт бодисын хорыг арилгана.

/293./ Уламжлалт монгол эмийн номхотголд будааны цууг өргөнөөр хэрэглэдэг. Будааны цууг ямар түүхий эдүүдийг ашиглан гарган авдаг вэ. Зөв хариултыг сонгоно уу.

1. Тутрага будаа
2. Буудай
3. Эрдэнэ шиш
4. Архи
5. Архины шаар

/294./ Уламжлалт монгол эмийн номхотголд хэрэглэх хатуу биет туслах материалд аль түүхий эд материалууд орох вэ. Зөв хариултыг сонгоно уу.

1. Арвай
2. Элс
3. Бал
4. Хар буурцаг
5. Буудай

/295./ Уламжлалт монгол эмийн номхотголд туслах материал хийх зорилго нь аль вэ. Зөв хариултыг сонгоно уу.

1. Эмт бодисын хорт үйлдлийг бууруулах ашигт үйлдлийг бадруулах
2. Эмт бодисын ширүүн чанарыг зөөлрүүлэх
3. Эмт бодисын чанарыг өөрчлөн эмчилгээний ач тусыг нэмэгдүүлэх
4. Эмийг боловсруулах буюу найруулахад дөхөм болгох
5. Эмийн амт чанарыг засах

/296./ Аль нь номхотгох арга вэ. Зөв хариултыг сонгоно уу.

1. Шингэн биетийг ашиглаж
2. Галын хүчийг ашиглаж
3. Гал ба шингэн биетийг ашиглаж
4. Шатаах
5. Дэвтээх

/297./ Эмт бодисыг хуурах зорилго

1. Эмт бодисын эмэнд хэрэглэгдэхгүй зарим бүрэлдэхүүнийг арилгана.

2. Чанар чадлыг тохиромжтой өөрчилнө.
3. Хурц догшин шаталтын чанар болон муу үйлдлийг бууруулах

4. Өмхий үнэрийг дарна.
5. Хэмхэлхэд дөхөм чанарыг хувиргахгүй хадгалах.

/298./ Эмчилгээний хэрэгцээнд тохируулах буюу улам сайн боловсруулахын тулд дэвтээх цагийг нь нилээд урт хугацаагаар байлгадаг. Зорилго нь юу вэ?

1. амьтнаас гарах арьс, хавтас, араг яс зэрэгт наалдаж буй бохир зүйлийг арилгах
2. холимог зүйлийг арилгах
3. хорт чанарыг бууруулах
4. эмчилгээний хэрэгцээг бүх чанараар бадруулах
5. зөөлрүүлэн хэрчих буюу бусад зүйлээр боловсруулах

/299./ Мана-4 тангийн чадал

1. Хий цусны хатгалгааг дарна
2. Хий цусны хатгалгааг дарна
3. Хижгийн халууныг боловсруулна
4. Халууныг боловсруулна.

5. Цайвар бор бадганыг дарна.

/300./ Цагаан тан эмийн бүрэлдэхүүнт орох эмт бодисуудыг сонго.

1. Арүр
2. Лидэр
3. Барүр
4. Гандигар
5. Жүрүр

/301./ Жигнэж номхотгох аргын зорилго

1. Эмт бодисын чанар чадлыг өөрчлөх
2. Хэрэглэх хэмжээг өргөтгөхийн төлөө
3. Эмт бодисын ашигт бүрэлдэхүүнийг хурааж хадгалахд ашигтай болгох

4. Эмт бодисын муу үйлдлийг багасгах
5. Хэрчиж зүсэхэд дөхөм болгохын төлөө

/302./ Чанаж номхотгох аргын зорилго

1. Хорт чанарыг багасгах
2. Хурц, ширүүн чанарыг зөөлрүүлэх
3. Муу үйлдлийг бууруулах
4. Эмт бодисыг цэвэршүүлэх
5. Ходоодны шингээлтэнд сайжруулах

/303./ Фталазолыг норсульфазолын оронд хэрэглэж болно. Яагаад гэвэл найрлагандаа норсульфазолтой.

/304./ Сульфаниламидыг сүрьеэ өвчнийг эмчлэхэд хэрэглэнэ. Яагаад гэвэл грам / + / / - / микробт нөлөөлнө.

/305./ Неграм антибиотик, сульфаниламидад дасал болсон микробт сайн нөлөөлнө. Яагаад гэвэл ихэнх нь задралгүй шээстэй ялгарна.

/306./ Нитроксолиныг шээсний замын өвчнүүдэд хэрэглэнэ. Яагаад гэвэл организмд задралгүй шээстэй ялгарна.

/307./ Сульфаниламидын эмчилгээг өвчний шинж тэмдэг арилнаас хойш 2-3 хоног үргэлжлүүлнэ. Яагаад гэвэл цус төлжилтөд эсрэг нөлөөлнө.

/308./ Төмрийн бэлдмэлийг хэрэглэхэд ходоодны хүчиллэгийг анхаарах нь чухал. Яагаад гэвэл давсны хүчил төмөр шимэгдэхэд оролцоно.

/309./ Төмрийн бэлдмэлийг гиперхром, цус багадалтад хэрэглэнэ. Яагаад гэвэл гемоглобины үндсэн бүрэлдэхүүн төмөр юм.

Төмрийн бэлдмэлийг гиперхром, цус багадалтад хэрэглэнэ. Яагаад гэвэл гемоглобины үндсэн бүрэлдэхүүн төмөр юм.

/310./ Төмрийн дутагдлын цус багадалтын үед вит С-г хэрэглэнэ. Яагаад гэвэл судасны ханыг бэхжүүлнэ.

/311./ Төмрийн бэлдмэлийг капсултай буюу бүрхүүлтэй шахмал хэлбэрээр гаргана. Яагаад гэвэл түүнийг хэрэглэхэд өтгөн хатна.

/312./ Ацетилсалицилын хүчлийг цусны бүлэгнэлтийг идэвхжүүлэх зорилгоор хэрэглэнэ. Яагаад гэвэл тромбоцитын агрегацийг багасгана.

/313./ Дипиридамолыг тромбозын үед хэрэглэнэ. Яагаад гэвэл титмийн судсыг өргөсгөнө.

/314./ Фурацилиныг ууж хэрэглэхгүй. Яагаад гэвэл антисептик.

/315./ Иодыг мэс засалчын гар, хагалгааны талбай ариутгахад хэрэглэнэ. Яагаад гэвэл иод исэлдүүлэгчийн бүлэгт орно.

/316./ Дараах эмийн хослолуудаас ходоодны шархлааны эмчилгээнд хэрэглэдэг “сонгодог гурвал”-ыг олно уу?

- A. Циметидин Амоксациллин Коллоид висмут
- B. Ранитидин Амоксациллин Коллоид висмут
- C. Метронидазол Амоксациллин Коллоид висмут
- D. Алмагель Амоксациллин Коллоид висмут
- E. Циметидин Метронидазол Коллоид висмут

/317./ Салицилатуудыг хэрэглэж байхад ямар гаж нөлөө илэрч болох вэ?

- A. Ходоодны шарх үүснэ
- B. Сонсголын мэдрэл гэмтэнэ
- C. Ясжилт өөрчлөгдөнө
- D. Бөөрний дутагдал үүснэ
- E. Ургийн гаж хөгжил үүснэ

/318./ Тетрациклиныг ходоодны хүчил саармагжуулах эмүүдтэй хамт хэрэглэвэл түүний микробын эсрэг нөлөө буурдаг. Үүний шалтгааныг олно уу?

- A. Тетрациклины шимэгдэлт саатна
- B. Тетрациклины хувирал түргэснэ
- C. Тетрациклины ялгаралт түргэснэ
- D. Тетрациклины тархалтын эзлэхүүн багасна
- E. Тетрациклины үйлчлэх хугацаа 1/2 богиносно

/319./ Нярай хүүхдийн эмийн кинетик ба динамикийн тухай дараах мэдээллүүдийн аль нь буруу вэ?

- A. Тархалтын эзлэхүүн V_d бага байна
- B. Эмийн хагас элиминацийн хугацаа $t_{1/2}$ удаан байна
- C. Элгэн дэх эмийн хувиралын эрчим сул байна
- D. Адренорецепторууд бүрэн ялгаран хөгжиж чадаагүй байдаг
- E. Эмийн клиренс удаан байна.

/320./ Бага насны хүүхдэд тосонд уусамхай /липофиль/ эмүүдийн тархалтын эзлэхүүн V_d хэрхэн өөрчлөгддөг вэ?

- A. Багасна
- B. Багасах буюу өөрчлөгдөхгүй
- C. Өөрчлөгдөхгүй
- D. Өөрчлөгдөхгүй буюу ихэснэ
- E. Ихэснэ

/321./ Эмийн бэлдмэлүүдийн уурагтай холбогдолт ямар хүчин зүйлээс хамаарах вэ?

- A. Эм хэрэглэх аргаас
- B. Физик химийн шинж чанараас
- C. Эмийн хэлбэрээс
- D. Эм бэлтгэх технологигоос
- E. Өвчтөний биеийн байдлаас

/322./ Дараах эмүүдээс аль нь пенициллиний бөөрний сувганцарын секрецийг хориглодог вэ?

- A. Диазепам
- B. Гентамицин
- C. Рифампицин
- D. Пробенецид
- E. Хинидин

/323./ Агааргүйтэний эсрэг хамгийн идэвхитэй нөлөөлөх эмийн бэлдмэлийг олно уу?

- A. Ампициллин
- B. Гентамицин
- C. Цефоперазон
- D. Метранидазол
- E. Тетрациклин

/324./ Салметеролын үйлдлийн үргэлжлэх хугацаа:

- A. 1-2 цаг
- B. 2-3 цаг
- C. 3-4 цаг
- D. 6-12 цаг
- E. 18-24 цаг

/325./ Богино үйлдэлтэй бетта-2-адреномиметикийг олно уу?

- A. Сальбутамол
- B. Аминофиллин
- C. Ипратропиум бромид
- D. Орципреналины сульфат
- E. Сальметерол

/326./ M1-холинорецепторыг сонгомлоор хориглон ходоодны секрецийг дарангуйлах нөлөөтэй бэлдмэлийг нэрлэнэ үү?

- A. Омепразол
- B. Циметидин
- C. Фамотидин
- D. Сукральфат
- E. Пиренципин

/327./ Пропранололын биохүрэхүй /F/ бага байдгийн шалтгааныг олно уу?

- A. Элгэнд системийн өмнөх элиминаци-д ордог
- B. Шимэгдэлт муутай
- C. Цусны плазмын уурагтай холбогддог
- D. Ходоод гэдэсний замд идэвхгүйдэг
- E. Биеээс хурдан ялгардаг

/328./ Ямар өвчний үед пропранололыг хэрэглэж болохгүй вэ?

- A. Элэгний циррозтой өвчтөнд
- B. Бөөрний архаг дутагдалтай өвчтөнд
- C. Гуурсан хоолойн багтраа
- D. Чихрийн шижин
- E. Ходоод гэдэсний шархлаатай бол

/329./ Кардиоселектив бетта-адреноблокаторыг нэрлэнэ үү?

- A. Пропранолол
- B. Атенолол
- C. Изопренилин
- D. Фентоламин
- E. Арфонад

/330./ 5-изосорбид мононитрат, изосорбид динитратаас юугаараа ялгаатай вэ?

- A. Элгээр өнгөрөхдөө системийн өмнөх элиминаци-д өртдөггүй
- B. Дасал үүсдэггүй
- C. Метгемоглобин үүсгэдэггүй
- D. Толгой өвтгөдөггүй

Е. Тэдгээрийн хооронд ялгаа байхгүй

/331./ Уртасгасан үйлдэлтэй үрэвслийн эсрэг нөлөөт эмийг нэрлэнэ үү?

А. Аспирин

В. Анальгин

С. Пироксикам

Д. Индометацин

Е. Ортофен